

# НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗАР



## 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

2019.12.30

---

## АГУУЛГА

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН** 3-14

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт  
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хэмжээний хэрэгжилт

Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хэрэгжилт

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН** 15

Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилт

Ерөнхий сайдын захирамжийн хэрэгжилт

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргаас зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** 16- 71

Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт

Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Хууль эрх зүйн чиглэлээр хийгдсэн ажил

Архив, албан хэрэг хөтлөлт

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа

Төсөв, санхүү, орлого бүрдүүлэлт

“Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ** 72- 75

Үйл ажиллагааны ил тод байдал

Хүний нөөцийн ил тод байдал

### **ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ** 76 - 84

Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар

Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний талаар

Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

---

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар нь тайлант хугацаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”, Агаарын тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар:

- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тус газарт хамаарал бүхий 2 зорилтын 3 заалтын хэрэгжилт 90%
- Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тус газарт хамаарал бүхий 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилт 100%
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 3 зорилт, 10 арга хэмжээний хэрэгжилт 94%
- Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан 11 арга хэмжээний биелэлт 64.5%-тай байна.

Байгууллагын бодлогын зорилтуудын хэрэгжилтийн тайланг сар, улирал, хагас жилээр нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хурлаар улирал тутам хэлэлцүүлж хэвшсэн ба биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүдэд тухай бүр тайлагнаж ажиллав.

Мөн

- Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Осол гэмтлээс сэргийлэх” үндэсний хөтөлбөрийн өөрийн байгуулагатай хамааралтай заалтын хэрэгжилтийг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2019 оны жилийн эцсийн байдлаар гарган албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлсэн;
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөний нэгдүгээр үе шатын хүрээнд 5 зорилтын 29 үйл ажиллагааны чиглэлийн 82 заалтын хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаас гаргуулан нэгтгээд байна.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст,
- “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг НЗДТГ-т
- “Иргэдийн оролцоотой хөгжлийн жил”-ийн биелэлтийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд, НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст,

- “Орон нутгийн удирдах ажилтны Улсын зөвлөгөөнд Монгол Улсын ерөнхий сайд У.Хүрэлсүхийн өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг НЗДТГ-т,
- Нийслэлийн 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан заалтын биелэлтыг хагас жилийн байдлаар болон жил эцсийн байдлаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд,
- Байгууллагын хэмжээнд зохион байгуулж үр дүнд хүрсэн онцлох ажлын тайланг гарган газрын даргын 2019.09.26-ны өдрийн 01/494 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын Байгаль орчны салбарт 2019 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилийн байдлаар гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст албан бичиг болон email хаягаар тус тус хугацаанд хүргүүлэн ажилласан.

#### **Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын хэрэгжилт:**

1. “Улаанбаатар төмөр замын зорчигчийн вагоны галлагааны зуухнаас гарах утааг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх” НАББ-2018/02 дугаартай гэрээний дагуу “Эм Ай Эс” ХК нь зорчигч тээврийн 10 вагоны зууханд түлшний шаталтаас агаарт дэгдэх тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу ислийг бууруулах төхөөрөмжийг суурилуулсан. Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/09 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ажлыг бүрэн хүлээн авч дууссан.
2. Нийслэлийн 2018 оны хөрөнгө оруулалтаар төвлөрсөн дулаан хангамжинд холбогдох боломжгүй төрийн өмчийн 10-аас доошгүй барилгын дулааныг байгальд ээлтэй технологиор шийдвэрлэх ажлын хүрээнд нээлттэй тендерт шалгарсан гүйцэтгэгч “Бест Энержи сейвинг” ХХК нь СХД-ийн 1 дүгээр хорооны цагдаагийн барилга, 176, 226, 227 дугаар цэцэрлэгүүд, БГД-ийн 11, 23 дугаар хорооны цогцолбор барилгууд, СБД-ийн 12, 19, 20 дугаар хорооны цогцолбор барилгууд, 248 цэцэрлэг буюу нийт 10 байршилд халаалтын цахилгаан тогоо болон тоног төхөөрөмжүүдийг бүрэн суулгаж, 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар туршилт тохируулга хийгдэж, зураг төсөв батлагдах шатандаа гүйцэтгэл 85%-тай байна.



*Зураг 1. Цахилгаан халаалтад холбосон байдал*

3. Нийслэлийн 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нүүрсээр галладаг зуухнуудыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбоход 4.0 тэрбум төгрөг батлагдсан. Энэхүү 4-н багц ажлын хүрээнд нийт 56 барилгын 33 зуухыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажил хийгдэж байна. Үүнээс:

- Баянзүрх дүүргийн 4-р хороонд байрлах зэвсэгт хүчний 084 болон 124 дүгээр ангиудыг дулааны шугамд холбох ажил бүрэн дууссан. Халаалтын 2 зуух, 10 барилга төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон.
- Баянзүрх дүүргийн 8-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн газар шорооны ажил гэрээний дагуу 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр дууссан. Халаалтын 2 зуух, 5 барилга төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон.
- Баянзүрх дүүргийн 8, 17 дугаар хорооны 6 иргэний 7 зуух, 7 барилга, 13 аж ахуйн нэгж байгууллагын 19 зуух, 20 барилга төвлөрсөн дулаан хангамжид холбох угсралтын ажил бүрэн дуусч, улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангасан.

Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сонгинохайрхан дүүргийн 7-р хорооны “Хилчин хотхон”-ы 5.1Гкал/ц-ийн дулааны хэрэглээ бүхий 7 орон сууц, 5 амины орон сууц, 2 үйлчилгээний барилга, 2 цэцэрлэгийн барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажил хийгдсэн.

4. Нийслэлийн Засаг даргын “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/584 дүгээр захирамжаар Сайжруулсан түлшний эрэлт нийлүүлэлт, түгээлт борлуулалт, нөөцлөлтийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт сайжруулсан түлшний агуулах барих арга хэмжээг баталсан. Нийслэлийн төсвийн 3,75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ХУД-ийн 10, СХД-ийн 1, 2, ЧД-ийн 19, БЗД-ийн 21 дүгээр хороодод сайжруулсан түлш нөөцлөх зориулалт бүхий тус бүр 1000 тонноос доошгүй багтаамжтай 5 агуулахын барилгыг 5 аж ахуйн нэгж барьж улсын комисст хүлээлгэн өгсөн.



Зураг 2. Сайжруулсан түлшний агуулах

5. Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 75,2 тэрбум төгрөгөөр хэрэгжиж буй агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан түлшний саравч барих, 100 квт-аас дээш хүчин чадалтай дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрөлгүй халаалтын зууханд утаа шүүгч /фильтер/ суурилуулахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрууд хамтран дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас гаргасан



халаалтын зуухны судалгааг нягтлан үзэж, 166 аж ахуйн нэгж, байгууллагын 290 халаалтын зууханд утаа шүүгч суурилуулах судалгааг гарган Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороонд 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 01/2051 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Утаа шүүгч суурилуулах ажлын хүрээнд БНХАУ-ын Century new power /tianjin/ international trade, Hebei yonghua environmental protection equipment, Jiangsu fengyu enviromental protection гэсэн 3 компанитай гэрээ байгуулж, агаарын чанарыг сайжруулах бүсийн 2,3 дугаар бүсэд байгаа халаалтын болон үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 290 зууханд утаа шүүгч суурилуулахаас 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 210 зууханд утаа шүүгч /фильтер/ суурилуулсан.



Зураг 3. Халаалтын зууханд утаа шүүгч суурилуулсан байдал

6. Агаарын чанарын хяналтын суурин харуулуудын тоног төхөөрөмжийг нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд шинэчлэхээр Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 12-ны А/1302 дугаар захирамж гарч худалдан авах ажиллагааг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулан ажиллаж байна.

**Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл**

Хүснэгт 1.

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Явцын мэдээлэл
<b>Зорилт 2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах</b>			
<b>Үйл ажиллагааны чиглэл 1. Хот суурин газрын “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг шинэчлэн тогтоож, халаалтын зориулалтаар шатааж хэрэглэхийг хориглох зүйлсийн жагсаалтыг гарган мөрдүүлэх</b>			
2.1.1	Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг тухай бүр шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг хангах	Бүсийг шинэчлэн тогтоосон шийдвэр, бүсэд мөрдөх журам	Агаарын тухай хууль, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын гаргасан шийдвэр зэргийг үндэслэн нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмын төслийг шинэчлэн боловсруулж Байгаль

			орчин, Аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2019 оны 08 дугаар сарын 14-ний А/433-А/820 дугаар хамтарсан тушаал захирамжаар баталсан. Нийслэлийн хэмжээнд журмыг мөрдүүлэн ажиллаж байна.
--	--	--	---

**Үйл ажиллагааны чиглэл 2. Дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг үе шаттайгаар хориглох**

<b>2.2.2</b>	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар хориглох	Түүхий нүүрсийг халсан агаарын чанарыг сайжруулах бүсүүдэд журмыг мөрдүүлэх	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол болон Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2019 оны 08 дугаар сарын 14-ний “Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмыг шинэчлэн батлах тухай” А/433-А/820 дугаар хамтарсан тушаал захирамжаар АЧ-ын 2, 3, 4 дүгээр бүсэд түүхий нүүрсний хэрэглээг зогсоосон.</p> <p>Зөвшөөрснөөс бусад хэрэгцээнд Улаанбаатар хотод 2019 оны 05 сарын 15-ны өдрөөс түүхий нүүрсний хэрэглээг хориглосон Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд авто тээврийн товчоод болон нүүрс тээвэрлэн оруулж ирэх боломжтой замуудад ажиллах 4 явуулын ажлын байрыг шинээр байрлуулан Өлзийт, Эмээлт АТШНТ, Гүнт, Морингийн даваа, Баянзүрх, Өлзийт-2, Баруун туруун, Гачуурт явуулын хяналтын цэгүүдээр эргүүл хяналтын 24 ажилтаныг шинээр томилон улсын байцаагч нийт 53, ЦЕГ-ын 48, Нийслэлийн онцгой байдлын газрын 18 албан хаагчид хамтран 24 цагийн турш хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 05.15-11.28-ны хооронд 137234 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, нийт 1117 тээврийн хэрэгслээр 28176 тн түүхий нүүрс зөвшөөрөлтэй нэвтэрч, 529 тээврийн хэрэгслээр 16757 тн нүүрс</p>
--------------	---	---	--

			дамжин өнгөрч, 2335 тээврийн хэрэгслээр 114846 тн угаасан нүүрс Таван толгой түлш ХХК-ийн үйлдвэр рүү нэвтэрч, 129 тээврийн хэрэгслээр 3542,6 тн түүхий нүүрсийг нэвтрүүлэлгүй буцааж ажилласан.
--	--	--	--

**Үйл ажиллагааны чиглэл 3. Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшний үйлдвэрийг дэмжин түүхий нүүрсний хэрэглээг орлуулах**

<b>3.3.1</b>	Нийслэлийн гэр хорооллын айл өрх, аж ахуй нэгж, байгууллагыг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлш үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх	Сайжруулсан түлшний үйлдвэрүүдэд үзүүлэх	<p>1. Сайжруулсан түлш үйлдвэрлэх ажлын хүрээнд стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангахаар “Таван толгой түлш” ХХК-ийн 2 үйлдвэр 3 ээлжээр ажиллаж байна.</p> <p>2. Сайжруулсан түлш нөөцлөх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/961, 2019 оны А/447 дугаар захирамжуудаар сайжруулсан түлшний агуулах барих газрын асуудлыг шийдвэрлэсэн. Нийслэлийн төсвийн 3,75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар БЗД-ИИН 21, СХД-ийн 1, 2, ЧД-ийн 19, ХУД-ийн 10 дугаар хороодод 1000 тонноос дээш түлш нөөцлөх 5 агуулахын барилгыг 5 аж ахуйн нэгж барьж улсын комиссд хүлээлгэн өгсөн.</p> <p>3. Сайжруулсан түлш түгээх борлуулах ажлын хүрээнд Нийслэлийн хэмжээнд сайжруулсан түлшний 8 хангамжийн бааз, 27 дундын цэг, 361 борлуулалтын цэг ажиллаж байна. Борлуулалтын цэгүүдийг 16 бүсэд хувааж, тээвэрлэлтийн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, өдөрт давхардсан тоогоор 90-130 рейс хийж 25 кг, 1 тонны савалгаатайгаар 1300-1700 тонн сайжруулсан түлшийг бөөний агуулах болон хангамжийн бааз, борлуулалтын цэгүүдэд хүргэж байна.</p>
<b>3.3.2</b>	Сайжруулсан түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох	Боловсруулсан түлш нөөцлөх цэг, борлуулалтын сүлжээ	Сайжруулсан түлш нөөцлөх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/961, 2019 оны А/447 дугаар захирамжуудаар сайжруулсан түлшний агуулах барих газрын асуудлыг шийдвэрлэсэн. Нийслэлийн төсвийн 3,75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар БЗД-ИИН 21, СХД-ийн 1, 2, ЧД-ийн 19, ХУД-ийн 10 дугаар хороодод 1000 тонноос



			<p>дээш түлш нөөцлөх 5 агуулахын барилгыг 5 аж ахуйн нэгж барьж улсын комиссд хүлээлгэн өгсөн.</p> <p>3Сайжруулсан түлш түгээх борлуулах ажлын хүрээнд Нийслэлийн хэмжээнд сайжруулсан түлшний 8 хангамжийн бааз, 27 дундын цэг, 361 борлуулалтын цэг ажиллаж байна. Борлуулалтын цэгүүдийг 16 бүсэд хувааж, тээвэрлэлтийн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, өдөрт давхардсан тоогоор 90-130 рейс хийж 25 кг, 1 тонны савалгаатайгаар 1300-1700 тонн сайжруулсан түлшийг бөөний агуулах болон хангамжийн бааз, борлуулалтын цэгүүдэд нийлүүлж байна.</p>
<b>Үйл ажиллагааны чиглэл 4. Гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхийн шөнө хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50-100 хувь хөнгөлөх</b>			
2.4.1	Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчний хөнгөлөх	Шөнийн цахилгаан эрчим хүчийг хөнгөлөх	Цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд нийслэлийн 6 дүүргийн 9 хороог агаарын чанарыг сайжруулах бүсэд нэмж хамруулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулж нийт 6 дүүргийн 138 хороо хамрагдаж байна. 2019 оны 12 сарын байдлаар нийт 129,000 хэрэглэгчидэд 102,2 сая кВт.ц-ийн 9,2 тэрбум төгрөгийн тарифын хөнгөлөлт үзүүлсэн байна
<b>Үйл ажиллагааны чиглэл 15. Агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийг бууруулах инновацийн судалгаа, технологийн хөгжлийг дэмжин санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, олон улсын сангуудаас санхүүгийн дэмжлэг авахад дэмжлэг үзүүлэх</b>			
2.15.2	Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбоогдоогүй алслагдсан төрийн байгууллагын дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүч болон бусад үр ашигтай технологи ашиглан шийдэх	53 хорооны барилгын дулааны хангамжийг шийдвэрлэсэн төсөл	Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй нийслэлийн 19 цэцэрлэгийн судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэсэн. Судалгааг үндэслэн Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо нь оюуны өмчийн эрхтэй цахилгаан бойлер суурилуулах “Бест Энержи Сэйвинг” ХХК-тай шууд гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу СХД-ийн 1 дүгээр хорооны цагдаагийн барилга, 176, 226, 227 дугаар цэцэрлэгүүд, БГД-ийн 11, 23 дугаар хорооны цогцолбор барилгууд, СБД-ийн 12, 19, 20 дугаар хорооны цогцолбор

		<p>барилгууд, 248 цэцэрлэг буюу нийт 10 байршилд халаалтын цахилгаан тогоо болон тоног төхөөрөмжүүдийг бүрэн суулгаж, 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар туршилт тохируулга хийгдэж, зураг төсөв батлагдах шатандаа гүйцэтгэл 85%-тай байна.</p> <p>Нийслэлийн 2018 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нүүрсээр галладаг зуухнуудыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбоход 4.0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд энэхүү 4-н багц ажлын хүрээнд нийт 56 барилгын 33 зуухыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажил хийгдсэн. Үүнд:</p> <p>-Баянзүрх дүүргийн 4-р хороонд байрлах зэвсэгт хүчний 084, 124 дүгээр ангиудыг дулааны шугамд холбох ажил бүрэн дууссан. Халаалтын 2 зуух, 10 барилга төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон.</p> <p>-Баянзүрх дүүргийн 8-р хороонд байрлах Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн газар шорооны ажил гэрээний дагуу 2019 оны 07 дугаар сарын 30-ний өдөр дууссан. 2019 оны 12 дугаар сарын байдлаар Халаалтын 2 зуух, 5 барилга төвлөрсөн дулаан хангамжид холбогдож гадна тохижилтийн ажил хийгдэж байна. Гүйцэтгэл-100%</p> <p>-Баянзүрх дүүргийн 8, 17 дугаар хорооны 6 иргэний 7 зуух, 7 барилга, 13 аж ахуйн нэгж байгууллагын 19 зуух, 20 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох угсралтын ажил бүрэн дуусч комисс ажиллах бэлтгэл ажил хангагдаж гүйцэтгэл-100% байна.</p> <p>2019 онд Халаалтын зуухыг буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох 950 сая төгрөг тусгагдаж УБЗАА-д үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд</p>
--	--	--

			УБЗАА-д дээр ажлуудыг хийж гүйцэтгэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулах тендер зарлахаар төлөвлөн ажиллаж байна.
<b>Үйл ажиллагааны чиглэл 16. Агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв”-ийг байгуулах</b>			
<b>2.16.1</b>	Агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологийг олон нийтэд таниулах “Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв” /Show room/-ыг нийслэлийн 3-аас доошгүй байршилд байгуулах	Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв	2019 онд Нийслэлийн СХД-2, БЗД-2, СБД-1, нийт 5 байршилд агаар орчны бохирдлыг бууруулахад хэрэгжүүлж буй арга хэмжээг сурталчлах, техник технологийн мэдээллийн төв байгуулахаар “Таван толгой түлш” ХХК, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. НХАА-ны газар нээлттэй тендер зарлаж гүйцэтгэгчээр “ТЭТҮ ХХК” шалгарч гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд гүйцэтгэл 80 хувьтай байна.
<b>Зорилт 3. Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагч бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах</b>			
<b>Үйл ажиллагааны чиглэл 3. Тээврийн хэрэгслийг хийн түлш, цахилгаан эх үүсвэрт шилжүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө багатай техник, технологи, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийж турших, нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд үе шаттайгаар шилжүүлэх</b>			
<b>3.3.3</b>	Нийслэлийн нийтийн тээврийн дизель автобусанд утааны тортог шүүгч DPF, түүнийг цэвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулах, байнгын үйлчилгээ хийх	Дизель автобусанд суурилуулсан DPF шүүлтүүрийг цэвэрлэх тоног төхөөрөмж, тогтмол үйлчилгээ	1. Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны “ЖАЙКА” байгууллага, Зам, Тээвэр хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2017 оны 09 дүгээр сарын 22-ний өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд “Нийтийн тээврийн автобусанд дизелийн тортгийн шүүлтүүр DPF (Diesel Particulate Filter) тоноглол суурилуулж утааны PM ялгарлын бууралтыг турших төсөл” хэрэгжүүлсэн. “Зорчигч тээврийн нэгтгэл”, “Зорчигч тээвэр гурав”, “Сутайн буянт” гэсэн 3 компанийн их багтаамжийн нийт 24 автобусанд дизель хөдөлгүүрийн тортгийн шүүлтүүр DPF (MoCobee CT-3 загвартай) болон иж бүрдлийг Япон Улсын жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжаар буюу үнэ төлбөргүй суурилуулж 2018 оны 07 сараас

			<p>эхлэн 1 жилийн хугацаанд хийж DPF төхөөрөмжийг суурилуулж хэрэглээнд нэвтрэх боломжтой болохыг баталгаажуулж 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотод хүлээлгэн өгсөн. Дээрх төслийн хугацаанд өдөрт дунджаар 1 автобуснаас шүүгдэж буй PM-ын хэмжээ 181 грамм буюу төсөл хэрэгжсэн нийт 11 сарын хугацаанд 585.2кг PM-ыг шүүсэн дүнг гарсан.</p> <p>2. Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газрын агентлаг НТГ, БНСУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамны харьяа Гадаад худалдааны Төлөөлөгчийн газар "КОТРО УЛААНБААТАР ГХГГ" харилцан тохиролцож тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааны хэмжээг бууруулах шүүлтүүр суурилуулах санамж бичгийг 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газраас Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ "Эй Эм Жи" ХХК-тай хамтран БНСУ-ын CERAKOM компанид үйлдвэрлэсэн дизель хөдөлгүүрээс ялгарах хорт утаа шүүгч "HUBRID" DPF, "ACTIVE" DPF төхөөрөмжийг БНСУ-д 2009 онд үйлдвэрлэсэн DEAWOO BS-106 маркийн их багтаамжийн 5 автобусанд суурилуулж туршилтын ажил 2018 оны 11-р сараас эхлэн хийгдэж байна. Уг ажлын хүрээнд "Эй Эм Жи" ХХК-иас туршилт судалгааны тайлан, хэмжилтийн дүнг хүлээн авч үзэхэд "HUBRID" DPF нь PM тортогжилтийг 93.2 хувь, "ACTIVE" DPF нь PM тортогжилтийг 79.6 хувь шүүсэн дүнтэй үргэлжилж байна.</p>
3.3.4	Нийтийн зорчигч тээврийн автобусанд "Эко жолоодлого"-ын хяналтын төхөөрөмжийг суурилуулж, нэвтрүүлэх, сурталчлан таниулах	<p>1. "Эко жолоодлого"-ын хяналтын төхөөрөмжийг суурилуулсан 10 автобус</p> <p>2. Туршилт, судалгааны ажлын тайлан</p> <p>3. Сургалт сурталчилгаа нэвтрүүлэх, сурталчлан таниулах</p>	Нийтийн зорчигч тээврийн автобусанд суурилуулсан "Эко жолоодлого"-ын хяналтын төхөөрөмжийг "Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ"-ын 10 автобусанд суурилуулж, туршилт хийгдсэн. "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ын 10

			<p>автобусанд 2018 оны 08 дугаар сарын 01-нээс 10-ны хооронд “Эко жолоодлого”-ын хяналтын төхөөрөмжийг дахин суурилуулж туршсан боловч мэдээлэл нь хангалттай цуглараагүй учраас боловсруулалт хийгдэх боломжгүй болсон.</p> <p>ЖАЙКА олон улсын байгууллагын “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх 3-р төсөл”-ийн төлөвлөгөөнд 2019-2021 онд эко жолоодлогын туршлагыг нийслэлд нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагын 80 автомашинд “эко жолоодлого”-ын хяналтын төхөөрөмжийг суурилуулна. Энэхүү ажлын хүрээнд Нийслэлийн түргэн тусламжийн төв, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ, Нийслэлийн төр захиргааны авто бааз, Хот тохижилтийн газар ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн судалгааг авахаар байгууллагын 2019 оны 06-р сарын 04- ний өдрийн 03/280 дугаарт албан бичгээр хүсэлт хүргүүлсэн. Дээрх байгууллагуудын 40 доошгүй тээврийн хэрэгсэлд эко жолоодлогын камер суурилуулах ажлыг 2020 оны 01 дүгээр сард “Жайка” төслийн багтай хамтран эхлүүлэхээр төлөвлөөд байна.</p>
--	--	--	---

**Зорилт 5. Орчны бохирдлыг бууруулахад иргэд, олон нийтийг оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх**

**Үйл ажиллагааны чиглэл 10. Агаар, орчныг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл, мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх**

<b>5.10.1</b>	Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллого явуулж, бүртгэл мэдээллийн цахим санг бүрдүүлэх	Агаарын бохирдлын эх үүсвэр, өрхийн бүртгэл, мэдээллийн сан	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 онд хэрэгжүүлэх “Гэр хорооллын нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналт, мониторинг, туршилт явуулах” арга хэмжээний хүрээнд нийслэлийн гэр хорооллын иргэдийн амьдрах орчны судалгааг явуулсан. Судалгааг 3902 ажилтан, нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын 95 хорооны 149 мянган өрхөөс авсан. Судалгааг ухаалаг
---------------	--	---	---

---

			гар утасны аппликейшн болон уламжлалт цаасан суурьт аргаар явуулсан. Судалгаагаар нийслэлийн гэр хорооллын иргэдийн орон сууцны төрөл, дулаан алдагдал, халаалтаа шийдсэн хэлбэр, цахилгааны хэрэглээ, цахилгааны аюулгүй байдал, сайжруулсан зуух хэрэглэдэг эсэх, түлшний хэрэглээ, үнс болон хаягдлыг хэрхэн зайлуулдаг, жорлонгийн төрөл, тоо, хашаандаа бохирын цооногтой эсэх зэрэг амьдрах орчны мэдээ мэдээллийг цуглуулсан.
--	--	--	--



---

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

а).Тус газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамаарал бүхий 10 тогтоол, 6 зөвлөмж, тэмдэглэл, 1 албан даалгаврын нийт 101 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг **Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан** [monitoring.ub.gov.mn](http://monitoring.ub.gov.mn) –д болон албан бичиг, цахим хаягаар тайлагнаж ажиллав.

- Улсын Их хурлын байнгын хорооны 35 заалтын хэрэгжилт 96,5%
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэлийн 5 заалтын хэрэгжилт 100%
- Засгийн газрын 8 тогтоолын 92 заалтын хэрэгжилтийн 94,2%
- Засгийн газрын хуралдааны 3 тэмдэглэлийн 64 заалтын хэрэгжилтийн хувь
- Засгийн газрын албан даалгаварын 1 заалт
- НИТХ-ын тогтоолын 3 заалт
- НИТХ-ын тэмдэглэлийн 35 заалт
- НИТХТ-ын тэмдэглэлийн 18 заалт
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн 5 тогтоолын 34 заалт
- НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн 1 заалт

Дээрх заалтуудын хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 95,85%-тай байна.

б) Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Нийслэлийн удирдах ажилтны 21 удаагийн шуурхай зөвлөгөөний 106 үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган, биелэлтийг НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн [ulaanbaatar.mn](http://ulaanbaatar.mn) сайтад байршуулан ажиллалаа. Шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврыг газрын удирдлага, хэлтсийн дарга нарт танилцуулан, 14 хоногийн ажлын биелэлт, тайлан болон 14 хоног тутмын төлөвлөгөөг тогтмол хугацаанд гаргуулж нэгтгэн НЗДТГ-ын ХШҮХ-ийн [monitoring@ulaanbaatar.mn](mailto:monitoring@ulaanbaatar.mn) цахим хаягаар цаг хугацаанд нь хүргүүлж тайлагнан ажиллаж байна.

БОАЖ-ын сайд болон НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2019 онд хамтран ажиллах гэрээнд заагдсан тус газартай хамаарал бүхий 3 зорилтын 5 заалтын биелэлтийг гарган ажиллалаа. Гэрээнд заагдсан 5 заалтын биелэлт 97.5 % -тай байна.

---

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

### **БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

***Агаарын тухай хууль, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд:***

Улаанбаатар хотын агаарын чанарыг 5 суурин харуулаар 6 төрлийн бохирдуулагч бодисыг 24 цагийн турш тасралтгүй хэмжиж, мэдээг 7 хоног, сар тутам баталгаажуулж гэрээнд заасан хугацаанд ЦУОШГ-т хүргүүлэн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-327 дугаарт тушаалаар батлагдсан “Агаарын чанарыг агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”-аар буюу агаарт агуулагдах хорт бодисын хэмжээг агаарын чанарын хүлцэх хэм хэмжээнд (MNS 4585:2016) харьцуулан гарах тоон утгыг хувьчлан тодорхойлж эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг өнгөөр илэрхийлэн олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.

Эрчим хүчний сайдын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 112 дугаар тушаалаар “Сайжруулсан хатуу түлш, техникийн шаардлага MNS5679:2014” стандартыг шинэчлэн боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэгт байгууллагын холбогдох 2 мэргэжилтэн орж ажилласан бөгөөд 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Стандарт, хэмжил зүйн газрын стандартчиллын техникийн хороогоор оруулж хэлэлцүүлэн дэмжигдсэнээр Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн С/16 дугаар тушаалаар батлагдсан.

Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг жил бүр шинэчлэн тогтоохоор заасны дагуу нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2019-2020 оны бүсийн төсөлд Багануур, Багахангай, Налайх дүүргийг шинээр хамруулсан. Улмаар эдгээр 3 дүүргийн гэр хорооллын айл өрхийн хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 100 хувь хөнгөлөх хүсэлтийг Байгаль орчин аялал жуулчлалын сайд бөгөөд орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга Н.Цэрэнбат, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 01/961 дугаартай албан бичиг хүргүүлсэн.


Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 433 дугаар тогтоолоор 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Нийслэлийн гэр хорооллын бүсэд орших хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тариф болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 100 хувиар, Нийслэлийн гэр хорооллын бүсэд орших хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 100 хувийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын хэрэглээний дээд хязгаараас илүү хэрэглэсэн цахилгааны тарифыг 50 хувиар хөнгөлсөн.

Агаарын тухай хууль, Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын гаргасан шийдвэр зэргийг үндэслэн нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмын төслийг шинэчлэн боловсруулж холбогдох 12 байгууллагаас санал авч тусгасан. Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоон, бүсэд мөрдөх журмын төслийг тус тус Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 06 -ны өдрийн хурлаар оруулан хэлэлцүүлж, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын Захирагчийн 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/433-А/820 дугаар хамтарсан тушаал, захирамжаар баталсан. Нийслэлийн хэмжээнд журмыг мөрдүүлэн ажиллаж байна.



Зураг4. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмыг хэлэлцүүлэв.



Зураг 5. Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах бүсүүд.

Хүснэгт 2. Агаарын чанарыг сайжруулах 2019-2020 оны бүсийн төсөл

Дүүрэг	1 дүгээр бүс /Хороо/	2 дугаар бүс /Хороо/	3 дугаар бүс /Хороо/	4 дүгээр бүс /Хороо/
Сонгинохайрхан	21	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 19, 20, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 30, 31, 32		12, 13, 14, 15, 16, 17, 18, 29
Баянзүрх	20	2, 4, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 17, 19, 21, 22, 23, 24, 27, 28,		1, 3, 6, 7, 15, 18, 25, 26
Чингэлтэй		7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19		1, 2, 3, 4, 5, 6
Сүхбаатар		9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20		1, 2, 3, 4, 5, 6, 7, 8,
Баянгол		9, 10, 11, 20, 21, 22, 23	16	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 12, 13, 14, 15, 17, 18, 19
Хан-Уул	12, 13, 14	4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 16		1, 2, 3, 15,
Багануур	Гэр хорооллын хороод			
Багахангай	Гэр хорооллын хороод			
Налайх	Гэр хорооллын хороод			
Тайлбар	Стандартын шаардлага хангасан зуух ашиглана.	Сайжруулсан хатуу түлш хэрэглэнэ.		Бүх төрлийн хатуу түлш хэрэглэхийг хорих бүс

“Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын 3.1.2-д “Агаарын чанарыг сайжруулах 1 дүгээр бүсэд хамаарах иргэн, хуулийн этгээдийн хэрэглээний нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгох асуудлыг агаарын бохирдлын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага зохион байгуулах” гэж заасны дагуу зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулсан. Үүнд:

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/52 дугаар тушаалаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт түүхий нүүрс тээвэрлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий 12 хүний бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсэг”-ийг байгуулсан. Ажлын хэсэг 2019 оны 08 дугаар сарын 26, 09 дүгээр сарын 18-ны өдөр хуралдаж, дээрх 5 хороонд түүхий нүүрс тээвэрлэх маршрут, 2019-2020 оны өвлийн улиралд хэрэглэх түүхий нүүрсний хэмжээг хороо тус бүрээс баталгаажуулан авч, 5 хороонд нийт 89084 тн нүүрс авахаар судалгааг гаргасан.





2019 оны 12 дугаар 10-ны байдлаар Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо 2148,9тн нүүрсийг 123 ширхэг зөвшөөрлийн бичгээр, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо 3376,85 тн нүүрсийг 125 ширхэг зөвшөөрлийн бичгээр, Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо 2382 тн нүүрсийг 124 ширхэг зөвшөөрлийн бичгээр, 13 дугаар хороо 2388тн нүүрсийг 152 ширхэг зөвшөөрлийн бичгээр, 14 дүгээр хороо 1618,4 тн нүүрсийг 259 ширхэг зөвшөөрлийн бичгээр, нийт **8537,3** тн нүүрсийг **783** ширхэг зөвшөөрлийн бичиг олгосон байна.

Түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичиг олгосон тайланг сар бүр дээрх 5 хороодоос авч нэгтгэн Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.



Зураг 8. “Түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичиг” –ээр олгосон бүртгэл тооцоо

**Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, хүрээлэн буй орчинд мониторинг хийх, Нэгжийн агаарын чанарын мэдээллийн санг бүрдүүлэх, агаарын чанарын 7 хоног ба сар тутмын мэдээг нэгтгэн баталгаажуулж мэргэжлийн байгууллагад хүргүүлэх чиг үүргийн хүрээнд:**

Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нэгжийн тасралтгүй ажиллагааг хангах зорилтын хүрээнд агаарын чанарын хяналтын сүлжээнд хамрагдсан 5 суурин харуулын мэдээг 7 хоног, сар тутам баталгаажуулж гэрээнд заасан хугацаанд ЦУОШГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Суурин харуулуудын хэмжилтийн өгөгдөл цуглуулах цаг 2019 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар 8208 цаг байх ёстой. Баталгаат өгөгдлийг 2019 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар 8208 цагийн өгөгдөл авахаас суурин харуул тус бүрээр үзүүлвэл:

- Толгойт - 8199 цаг – 99%
- Телевиз - 8208цаг – 100%
- Амгалан - 7475 цаг – 99%
- Нисэх - 7938 цаг –96 %
- Баянхошуу 8185 цаг – 99% байна.

Суурин харуулуудын төхөөрөмжүүдийн ажилласан цагаар үзүүлэв:



**Хүснэгт 3. Улаанбаатар хотын агаарын чанарын хяналтын суурин харуулуудын төхөөрөмжүүдийн ажилласан цаг**

12/08/2019											Төхөөрөмж -үүдийн ажилласан цаг
Хэмжилт -ийн төрлүүд	Амгалан		Нисэх		Толгойт		Телевиз		Баянхошуу		
	Хэмжих цаг		Хэмжих цаг		Хэмжих цаг		Хэмжих цаг		Хэмжих цаг		
	8208	хувь	8208	хувь	8208	хувь	8208	хувь	8208	хувь	
	Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		Хэмжсэн цаг		
NO2	5829	71%	7939	96%	8188	99%	8208	100%			91.5%
CO			3810	24%							24%
SO2	7379	89%	7234	88%	8099	98%	7804	95%	7709	93%	94%
PM10	7475	91%	7939	96%	8187	99%	8208	100%	8097	98%	96.8%
PM2.5	7475	91%	7939	96%	8187	99%	8208	100%	8082	98%	96.8%
Ажилласан хувь		85.5%		80%		98%		98.7%		96.3%	
Нийт	Суурин харуулын ажилласан цаг <b>91.7%</b>										

Толгойт, Баянхошуу, Нисэх, Амгалан, МҮОНРТ-ийн суурин харуулын төхөөрөмжүүдийн насжилт дууссан сэлбэг шүүлтүүрүүдийг солих, хийн тохируулгыг хуваарьт хугацаанд хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Тайлбар: Телевиз, Толгойт, Амгалангийн суурин харуулын СО-ийн төхөөрөмжүүд нь 2009 онд манай байгууллагад суурин харуул хүлээлгэн өгөхөд өмнө нь ашиглагдаж байгаад дагалдан ирсэн төхөөрөмжүүд бөгөөд ашиглалтын хугацаа дуусч доголдож эхэлсэн. Дээрх тоног төхөөрөмжүүдийг 2019-2020 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авахаар Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сар 12-ны А/1302 дугаар захирамж гаргуулсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар дээр хийгдэж байна.

**Агаар бохирдуулагч эх үүсвэр тус бүрийн судалгаанд үндэслэн хортой бодисуудын тархалтын загварчлалыг гаргаж, тэдгээрийн нөлөөллийг тодорхойлох ажлын хүрээнд:**

Японы Олон Улсын Хамтын ажиллагааны “ЖАЙКА” байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 3 дугаар шатыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөдөлгөөнт эх үүсвэрээс ялгарч буй бохирдлыг тооцох судалгааны ажил хийгдэж байна. Судалгааны ажлын хүрээнд хөдөлгөөний эрчим тоолох ажлыг 9 дүгээр сард Геозураглал ХХК гүйцэтгэж 45 цэг дээр камераар болон гар тооллогын аргаар хөдөлгөөний хурд хэмжих судалгааг хийсэн. Тооллого судалгааны явцад Японы Олон улсын байгууллагын Агаар, орчны тархалтын загварчлалын модель, агаарын бохирдыг бууруулах арга хэмжээний үнэлгээ хариуцсан

мэргэжилтэн Наката Шинья, Авто машинд авах арга хэмжээ, Хөдөлгөөнт эх үүсвэрийн хаягдал утааны хэмжилт хариуцсан мэргэжилтэн Окабэ Жюн нартай хамтран хяналт тавьж ажилласан.



Зураг 9. Хөдөлгөөнт эх үүсвэрээс ялгарч буй бохирдлыг тооцох судалгаа хийж байгаа нь

2017, 2018 оны “Агаар бохирдуулагч эх үүсвэрийн инвенторын тайлан”-г шинэчлэх ажлын хүрээнд ЖАЙКА-гийн мэргэжилтний дэмжлэгтэйгээр 2017, 2018 оны суурин эх үүсвэрийн үйл ажиллагааны өгөгдөл цуглуулах, боловсруулах, ялгарлын хэмжээг тооцоолох ажил хийгдэж байна. Одоогоор эх үүсвэрүүдийн үйл ажиллагааны өгөгдөл цуглуулах ажил 90%-тай явагдаж байна. Бусад эх үүсвэрүүдийн үйл ажиллагааны цуглуулсан өгөгдөлд шинжилгээ хийж, Жайкагийн мэргэжилтнээс зааварчилгаа авч ажиллаж байна.

Агаар бохирдуулах түгээмэл бодисуудын хэмжилтийн дүнг боловсруулан баталгаажуулж агаарын бохирдлын нөлөөллийг агаарын чанарын индексээр илэрхийлж өдөр бүр тодорхойлон ажиллаж байна.

Хүснэгт 4. 2019 оны халаалтын улирлын агаарын чанарын мэдээ / 2019 оны 1-р сараас 12-р сарын 08 хүртэл /

Суурин харуул	Маш их бохирдол той	Их бохирдол той	Бохирдол той	Бага бохирдол той	Хэвийн	Цэвэр	Хэмжсэн хоногийн тоо
	Хоногийн тоо						328
Амгалан Автозам орчим/	-	-	18	159	74	77	
Толгойт /Гэр хороолол орчим/	-	5	10	138	74	101	
Нисэх	-	3	20	182	47	76	

/Гэр хороолол орчим/							
Баянхошуу /Гэр хороолол орчим/	12	13	32	168	45	58	
Телевиз /Гэр хороолол орчим/	-	14	22	131	38	123	
Дүн	12	35	102	778	278	435	

**Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны үнийн хөнгөлөлтөнд хамруулах зорилтын хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор батлагдсан "Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 433 дугаар тогтоолоор Нийслэлийн гэр хорооллын бүсэд орших хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд оройн 21.00 цагаас өглөөний 06.00 тэглэх шийдвэр гарсан. Тогтоолын дагуу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлж эхэлсэн. Цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд нийслэлийн 6 дүүргийн 9 хороо хамрагдаж 2019 оны 12 сарын байдлаар нийт 129,000 хэрэглэгчидэд 102,2 сая кВт.ц-ийн 9,2 тэрбум төгрөгийн тарифын хөнгөлөлт үзүүлсэн байна.

Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2019-2020 оны бүсэд Багануур, Багахангай, Налайх дүүргийг шинээр хамруулсан. Улмаар эдгээр 3 дүүргийн гэр хорооллын айл өрхийн хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 100 хувь хөнгөлөх хүсэлтийг Байгаль орчин аялал жуулчлалын сайд бөгөөд орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга Н.Цэрэнбат, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт Нийслэлийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 01/961 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Одоогоор эцэслэн шийдвэр гараагүй байна.

**Нийслэлийн гэр хорооллын айл өрхийн түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

Түүхий нүүрсний хэрэглээг сайжруулсан түлшинд шилжүүлж агаарын бохирдлыг 50 хүртэл хувиар бууруулах зорилт тавьж сайжруулсан түлшийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх ажлын хүрээнд стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангахаар "Таван толгой түлш" ХХК-ийн 2 үйлдвэр 3 ээлжээр ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол нийслэлд 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжин, нийслэлийн 6 дүүргийн цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж

ахуйн нэгжээс бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон. Энэхүү тогтоолын хүрээнд доорхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Сайжруулсан түлшний түгээлт, тээвэрлэлтэнд хяналт тавих ажлын хүрээнд 2019 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн байрнаас машинд ачилт буулгалт хийх хугацаа, үйлдвэрээс дундын хангамжийн цэгүүд рүү тээвэрлэлт хийх замын урт, хугацаа, ачаалал, дундын цэгүүдийн орц гарц, түлш агуулах багтаамжийн судалгааг хийж ажилласан.



Зураг 10. Сайжруулсан түлшний үйлдвэрлэл, тээвэрлэлтэд хяналт тавьж байгаа нь

Нийслэлийн БГД, БЗД, СХД, СБД, ЧД, ХУД дэх “Таван толгой түлш” ХХК-тай сайжруулсан түлш борлуулах гэрээтэй ажиллаж байгаа борлуулагч нартай уулзаж, түлшний нөөц, хангалт, борлуулалт, картаар үйлчилж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.



Зураг 11. Сайжруулсан түлшний нөөцлөлт, борлуулалтад хяналт тавьж байгаа нь

Сайжруулсан түлш нөөцлөх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/961, 2019 оны А/447 дугаар захирамжуудаар сайжруулсан түлшний агуулах барих газрын асуудлыг шийдвэрлэсэн. Нийслэлийн төсвийн 3,75 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар БЗД-ийн 21, СХД-ийн 1, 2, ЧД-ийн 19, ХУД-ийн 10 дугаар хороодод 1000 тонноос дээш түлш нөөцлөх 5 агуулахын барилгыг 5 аж ахуйн нэгж барьж улсын комиссд хүлээлгэн өгсөн.



Нийслэлийн хэмжээнд сайжруулсан түлшний 8 хангамжийн бааз, 27 дундын цэг, 361 борлуулалтын цэг ажиллаж байна. Борлуулалтын цэгүүдийг 16 бүсэд хувааж, тээвэрлэлтийн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, өдөрт давхардсан тоогоор 90-130 рейс хийж 25 кг, 1 тонны савалгаатайгаар 1300-1700 тонн сайжруулсан түлшийг бөөний агуулах болон хангамжийн бааз, борлуулалтын цэгүүдэд 24 цагаар тээвэрлэлт хийж байна.



Зураг 12. Сайжруулсан түлшний тээвэрлэлт, түгээлтийн байдал

Сайжруулсан түлшний түгээлт, тээвэрлэлт гүйцэтгэх гэрээг "Энх дэлгэрэх зам", "Хийморь Эйч Ар Трак", "Тэс менежмент", "Лэнгийн цагаан овоо", "Эрдэнэс нар хур", "Ньюлаксури констракшн", "Мөнх Алтан зам", "Ганжуур цамхаг" зэрэг 8 аж ахуйн нэгж компаниудтай байгуулан тээвэрлэлтийн урамшууллыг олгон ажиллаж байна. 2019 оны 12 сарын 23-ны байдлаар 158,166 тонныг тээвэрлээд байна.

Нийслэлээс тээвэрлэлтийн санхүүжилтэд 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 1.781.689.707 /нэг тэрбум долоон зуун наян нэгэн сая зургаан зуун наян есөн мянга долоон зуун долоон/ төгрөгийг олгоод байна.

Түлшний үнийг тонн тутам 150,000 төгрөг, борлуулалтын тонн тутамд 15,000 төгрөгийн урамшуулал олгох тухай Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 19/12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/987 дугаар захирамжаар түлш борлуулагч иргэдийн ажлын байрыг баталгаажуулах, түлшний үнийн хөөрөгдлөөс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Сайжруулсан түлшний борлуулалтын урамшуулал олгох гэрээг боловсруулан НЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс болон "Таван толгой түлш" ХХК-иас санал авч тусган 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр "Таван толгой түлш" ХХК-тай гэрээ байгуулсан. Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар нь Таван Толгой түлш ХХК-иас ирүүлсэн шаардлага хангасан санхүүгийн баримтад үндэслэн 191 гэрээт борлуулагч нарт борлуулалтын урамшуулал 915.831.624 төгрөгийг 2019 оны 12 дугаар сарын 06-ны байдлаар "Таван толгой түлш" ХХК-ийн дансанд шилжүүлээд байна.

Сайжруулсан түлшний хяналтын "Сайн карт"-ыг "Таван толгой түлш" ХХК, дүүрэг хороодтой хамтран 2019 оны 09 дүгээр сарын 20-ноос эхлэн гэр хорооллын айл өрхөд тараасан бөгөөд 12 дугаар сарын 09-ний байдлаар нийт 206258 айл өрхөд карт олгож,

---

153086 ширхэг картыг бүрэн идэвхжүүлэн хэрэглээнд нэвтрүүлж, 53172 ширхэг картыг бүртгэлжүүлэн идэвхжүүлэх ажил хийгдэж байна.

Засгийн газрын 10 дугаар сарын 9-ны хуралдаанаар нийслэлд амьдарч буй гэр хорооллын айл өрхүүдэд нэг удаа угаарын хийн мэдрэгчийг үнэгүй тараахаар болж уг ажлыг 11 дүгээр сарын 1-нээс айл бүрт тарааж эхлэх ажлыг БОАЖ-ын сайд Цэрэнбат, хотын С.Амарсайхан нарт даалгасны дагуу ажлын хэсэг байгуулагдаж, үйлдвэрлэгч байгууллагатай шууд гэрээ байгуулан одоогоор тээвэрлэлт, нийлүүлэлтийн ажил хийгдэж байна. Угаар мэдрэгч төхөөрөмжийг нийслэлийн агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд тараах бэлтгэл ажил хийгдэж байна.

***Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдоогүй алслагдсан төрийн байгууллагын дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүч болон байгальд ээлтэй технологи бусад үр ашигтай технологи ашиглан шийдэх ажлын хүрээнд :***

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны төлөвлөгөөнд төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй 2 сургуулийн халаалтын зуухыг орчин үеийн дэвшилтэд технологи ашиглахаар шийдвэрлэж Сонгинохайрхан дүүргийн 122 дугаар сургуулийг газрын гүний дулааны насос суурилуулж халаалтыг асуудлыг шийдвэрлсэн бөгөөд мөн дүүргийн 129 дүгээр сургуулийн халаалтыг Япон улсын Rinnai KusaKawa төслийн хүрээнд хийн халаалтын системд бүрэн шилжүүлсэн.

***“Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхүүдийг сайжруулсан түлшээр хангах ажлын хүрээнд:***

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр, Морингийн даваа орчмын 572 айл өрхөд 60тн сайжруулсан түлш тараан түүхий нүүрс болон сайжруулсан түлшний харьцуулсан хэмжилт хийж айл өрхүүдээс сайжруулсан түлшний хэрэглээний хандлагыг тодорхойлох судалгаа авсан.

Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Агаарын бохирдолтой тэмцэх газар хамтран амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 20000 зорилтот бүлгийн өрхүүдийн судалгааг гаргасан.

Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02/11 дугаар бүхий албан бичгээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 1200 тн сайжруулсан түлш нийлүүлэх ажлын даалгаврыг хүргүүлсэн боловч Нийслэлийн аудитын газраас санхүүжилтийг татсан.

Нийслэлийн 2019 оны хөрөнгө оруулалтаар агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан түлшээр хангах дэмжлэг үзүүлэх саналыг боловсруулан НЗДТГ-т хүргүүлж, “Зорилтот бүлгийн өрхүүдэд сайжруулсан түлш олгох тухай” Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/1256 дугаар захирамж батлагдсан. Уг захирамжийн хүрээнд нийслэлийн 1666 өрхүүдэд сайжруулсан түлш олгох бөгөөд Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, “Таван толгой түлш” ХХК-тай гэрээ байгуулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

***Нийслэлийн өмчийн барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлын хүрээнд:***

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн зөвлөлийн хуралдаанаар УБЗАА-тай хамтран Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа



явуулж буй 16-100квт хүчин чадалтай нам даралтын 2209 ширхэг халаалтын зуух, 100квт-аас дээш хүчин чадалтай 451 зуухнуудын ашиглалт үйл ажиллагааг бодлогын түвшинд шийдвэрлэн ажиллах үүрэг чиглэлийг өгсөн. Энэхүү үүрэг чиглэлийн дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/147 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан 16-100квт хүчин чадалтай 2209 зуух байгаагаас УБЦТС ТӨХК-иас дэд станц, шугам тоноглол өргөтгөхгүйгээр шууд холбох боломжтой 469 нам даралтын зуухыг буулгах горимын тооцоо гарч 2019 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар 249 зуухыг цахилгаан халаалтад бүрэн шилжүүлсэн.



Зураг 13. Халаалтын зуухыг буулгаж түүхий нүүрсний хэрэглээг багасгасан байдал

2019 оны 08 дугаар сарын 01-13 ны өдрийг дуустал Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, нийслэлийн Байгаль орчны газрын холбогдох мэргэжилтнүүд хамтран 16-100квт бага оврын хүчин чадалтай халаалтын зуухтай иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын системийн судалгааг гаргах, түүхий нүүрс түлж буй БГД, БЗД, СХД, СБД, ЧД, ХУД дүүргүүдийн халаалтын зуухтай аж ахуйн нэгжүүдэд түүвэрчлэн очиж хяналт шалгалт хийсэн.

Энэхүү хяналт шалгалтын үр дүнд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-уул, дүүргүүдийн 50 зуух цахилгаан халаалтад шилжиж, 2019 оны 12 дугаар сарын байдлаар 10 зуух төвлөрсөн дулаан хангамжид бүрэн холбогдож түүхий нүүрсний жилийн хэрэглээ 700 тн-оор буурсан.



Зураг 14. Төвлөрсөн дулаан хангамжид шилжсэн аж ахуйн нэгжийн төлөөлөл

Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 19/15 дугаар тогтоолоор агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа бага чадлын 16-100квт хүчин чадалтай 1740 ширхэг халаалтын зуухыг сайжруулсан түлшээр хангах, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба болон “Таван толгой түлш” ХХК-д үүрэг болгосон. Энэхүү ажлыг хэрэгжүүлэх зорилгоор бага чадлын зуухнуудын халаалтын улиралд хэрэглэх сайжруулсан түлшний хэмжээ болон шинээр бүртгэлд ороогүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын холбогдох мэдээллийг УБЗАА-д бүртгэж дээрх 1740 зуухнаас гадна шинээр бүртгэлд ороогүй зуухны мэдээллийг нэгтгэн бүртгэл хийж халаалтын улиралд хэрэглэгдэх сайжруулсан түлшний хэмжээг тодорхойлон 7 хоног бүрийн эхний өдөр УБЗАА-аас “Таван Толгой Түлш” ХХК руу албан бичгээр үүрэг болгон зохион байгуулалтын арга хэмжээг авч, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

**Хүснэгт 5. 100 квт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухны цахилгаан, хий, төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон байдал:**

Шалгуур үзүүлэлт	Цэцэрлэг	Сургууль	Бусад барилга байгуулаж
Төвлөрсөн дулаан хангамжид холбогдсон зуухны тоо			58
Цахилгаан халаалтад шилжсэн зуухны тоо	19		7
Хийн халаалтад шилжсэн зуухны тоо		4	
Нийт	19	4	65
Нэгтгэл	88 зуух		

Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын даргын баталсан 2019 оны 02-01/21 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний цэгүүд, барилга байгууламжуудын харуул хамгаалалтын байр, аялал зугаалга, амралт сувиллын газруудын зуухыг цахилгаан халаалтад бүрэн шилжүүлэх ажлын хүрээнд авто машин засвар, угаалга-130, дугуй засвар-142, түц-197, харуулын

байр-68, хүнсний дэлгүүр-483, эрүүл мэндийн байгууллага-1 цэцэрлэг-3, сургууль-4, бусад-52 нийт 1080 зуухыг цахилгаан халаалтад шилжүүлсэн.

Хүснэгт 6. Цахилгаан халаалтад шилжсэн зуухны бүртгэл

Дүүрэг	Үйл ажиллагааны чиглэл								
	Авто машин засвар, угаалга	Дугуй засвар	ТУЦ	Харуулын байр	Хүнсний дэлгүүр	Эрүүл мэндийн байгууллага	Цэцэрлэг	Сургууль	Бусад
БГД	51	25	32	14	108				8
БЗД	16	50	35	18	89		1	1	2
ХУД	18	15	34	10	45			1	5
СБД	27	22	52	6	66	1	1		12
СХД	13	16	17	16	68			1	9
ЧД	5	14	27	4	107		1	1	16
<b>НИЙТ ДҮН</b>	<b>130</b>	<b>142</b>	<b>197</b>	<b>68</b>	<b>483</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>52</b>
	<b>1080</b>								

**Иргэдэд экологийн боловсрол олгох зорилтын хүрээнд:**

“Иргэдийн оролцоотой хөгжлийн жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагаас хийж хэрэгжүүлж байгаа болон 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн судалгаа, шинжилгээнд суурилсан шинэ санал санаачилга, шинэлэг байдал бүхий ажил, арга хэмжээний /төсөл хөтөлбөр/ мэдээлэл солилцох, танилцуулах, цаашид хэрэгжүүлэхэд тулгамдсан, бэрхшээлтэй асуудлыг нэгтгэж, ажлын санал боловсруулсан.

Уг саналыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчдэд танилцуулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллах Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, ногоон хөгжлийн хороотой хамтран “Агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе” сэдэвт хоёр дахь шатны хэлэлцүүлгийг 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр “Хангарди” ордны хурлын “Их танхим”-д зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт салбар хороодын дарга нар, агаарын бохирдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 70 гаруй ААНБ, төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн төлөөлөл оролцож агаарын бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх Зөвлөх баг байгуулахад чиглэгдсэн.



Зураг 15. “Агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгээ” хэлэлцүүлэг

Эрүүл мэндийн яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо, Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран “Түүхий нүүрсний хор уршгийг иргэдэд таниулах” өдөрлөгийг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулан түүхий нүүрснээс татгалзах, эрүүл мэндээ хэрхэн хамгаалах, зөв дадал хэвшлийг хэрэглээндээ нэвтрүүлж цаашид агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэж нэгэн зүгт хамтдаа тэмцэхийг иргэд, олон нийтэд уриалж сурталчлан ажилласан.



Зураг 16. Түүхий нүүрсний хор уршгийг иргэдэд таниулах өдөрлөгийн үеэр 2016.05.15

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/440 дүгээр захирамж болон нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 380 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “Улаанбаатар марафон”, “Автомашингүй өдөр-2019” өдөрлөг Сүхбаатарын талбайд 2019 оны 05 дугаар сарын 18-ны өдөр болсон. Уг өдөрлөгийн үеэр НАБТГ-аас “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, түүнийг хэрэгжүүлэх талаар хийгдэж байгаа ажлууд, түүхий нүүрс хүний эрүүл мэндэд ямар хор уршиг үзүүлдэг талаар олон нийтэд мэдээлэл өгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажилласан.






Зураг 17. “Автомашингүй өдөр -2019” өдөрлөг 2019.05.18.

Өдөрлөгийн үеэр иргэдээс “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” монгол улсын засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоол, сайжруулсан түлш, агаарын чанарын мэдээллийг хаанаас авдаг зэрэг агуулгаар санал асуулга авч ажиллалаа.

Түүхий нүүрс хэрэглэхийг 2019 оны 05 сарын 15-ны өдрөөс буюу өнөөдрөөс хориглох арга хэмжээ хэрэгжиж байна. Та үүнийг дэмжиж байна уу ?



Зураг 18. Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн талаарх иргэдийн санал бодол



Зураг 19. Сайжруулсан түлшний талаарх иргэдийн байр суурь

Сайжруулсан түлшний хэрэглээ агаарын бохирдлыг бууруулах шийдэл мөн гэж 79% нь, мэдэхгүй 18% нь, үгүй гэж 3 хувь нь хариулсан бол Агаарын бохирдлыг бууруулахад таны оруулж чадах хувь нэмрийн тухайд 22 буюу 40% нь гэр байшингаа дулаалах, 17 буюу 30% нь халаалтаа цахилгаанаар шийдэх, 16 буюу 29% нь сайжруулсан түлш тогтмол хэрэглэх гэж хариулсан байна.

Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, холбогдох нийслэлийн агентлагуудтай хамтран “Цэвэр агаартай-Авто машингүй өдөр” өдөрлөгийг 2019 оны 09 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Уг өдөрлөгт агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хийн түлш, дулаалгын компани, сайжруулсан түлш, сайжруулсан зуух, цахилгаан халаалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулж, тус байгууллагууд хүний эрүүл мэнд болон байгальд ээлтэй бүтээгдэхүүн, сүүлийн үеийн дэвшилтэт технологийн шийдлийг иргэдэд сурталчлан оролцсон.



Зураг 20. “Цэвэр агаартай-Автомашингүй өдөр” өдөрлөг

Өдөрлөгийн хүрээнд 5000 гаруй хүнд мэдээлэл хүргэж, байшин сууцны дулаалга хэрхэн хийх гарын авлага, ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага MNS 5216:2016, ус халаах зуухны техникийн ерөнхий шаардлага MNS 5043:2016 болон төслийн танилцуулга зурагт хуудсыг 2000 гаруй хүнд хүргэж ажиллалаа. “Ногоон зээлийн сан”-гаас зээл авах талаар тодорхой мэдээллүүдийг Хаан банк, Хас банк, Төрийн банк давхардсан тоогоор 6000 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажилласан.



Зураг 21. Ногоон зээлийн сан”-гаас зээл авах талаар Хаан банк, Хас банк, Төрийн банкууд сурталчлан ажиллав.

---

Дэлхийн Банкны санхүүжилттэй “Улаанбаатар хотын Цэвэр Агаар” төслийн хүрээнд “ДУЛААЛГА АЯН” хөтөлбөр 3 дахь жилдээ хэрэгжиж байна. “ДУЛААЛГА АЯН” хөтөлбөрийн хүрээнд төслийн шалгуур хангасан иргэдэд заавар зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, төсөлд хамруулах зэрэг арга хэмжээнүүдийг “Цэвэр агаар” төсөлтэй хамтран хэрэгжүүлсэн. “ДУЛААЛГА АЯН” нь 2019 оны 04 дүгээр сарын 11-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэсэн. Төслийн хүрээнд ЧД-ийн 124-р цэцэрлэг, БГД-ийн 17-р цэцэрлэгийг тус тус дулаалсан бөгөөд 6 дүүргийн 101 өрхийн байшинг иж бүрэн дулаалсан.

Тус байгууллагаас “Утааны эсрэг ээж аавууд” төрийн бус байгууллагатай хамтран “ДУЛААЛЦГААЯ” сэдэвт дулаалгын ахисан түвшний сургалтын 2019 оны 06 сарын 11—ээс 09 сарын 15 хүртэл хугацаанд зохион байгуулж сургалтаар 20 иргэнийг мэргэшүүлэн сургасан.

Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдийн ЗДТГ-ын хэлтэс, харьяа агентлагууд, орон нутгийн өмчит байгууллагууд, 99 хороо, эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн болон өрхийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн нийт 440 удирдах албан тушаалтнууд оролцсон “ТҮЛШЭЭ НӨӨЦӨЛБЭ” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 2019 оны 06 сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уулзалт хэлэлцүүлгээр 6-7 дугаар сард төрийн албан хаагчдад дараа төлбөрт нөхцлөөр сайжруулсан түлш худалдан авахад үзүүлэх хөнгөлөлт, сайжруулсан түлшний чанар, үнийн талаар мэдээлэл өгч ажиллалаа.

***Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 43, 62-р тогтоолуудыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудас, олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын хүрээнд:***

Олон нийтэд агаарын бохирдол, түүний сөрөг үр дагавар, агаарын бохирдлоос хамгаалах энгийн арга, эрүүл зөв амьдралын хэвшил, сайжруулсан түлшний зөв хэрэглээг агаарын чанарыг сайжруулах 2, 3 дугаар бүсийн айл өрхүүдэд сурталчлах зорилгоор Улаанбаатар, Эс Би Эн, Масс, Монголиан ньюс чаннел телевизүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Гэрээний дагуу Улаанбаатар телевизээр 42, 96 секундын 2 шторкийг өдөрт 2 удаагийн давтамжтай нийт 14 удаа, Эс Би Эн телевизээр 42, 96 секундын 2 шторкийг өдөрт 1 удаа нийт 31 удаа, Масс телевизээр 42, 96 секундын 2 шторкийг өдөрт 8 удаагийн давтамжтай нийт 116 удаа, Монголиан ньюс чаннел телевизээр 42, 96 секундын 2 шторкийг өдөрт 2 удаагийн давтамжтай нийт 31 удаа иргэд олон нийт хүргэсэн.

Мөн Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахад хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд нийгмийн сүлжээгээр сурталчилах зорилгоор “Зөв мэдээлэл холбоо” НҮТББ-тай 5 сарын хугацаатай “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан “Цэвэр агаартай хот” цахим хуудас, [www.zuv.mn](http://www.zuv.mn), [www.arслан.mn](http://www.arслан.mn), [www.ontsloh.mn](http://www.ontsloh.mn), [www.mass.mn](http://www.mass.mn) цахим хуудсуудаар сурталчилсан бөгөөд нийт 24 постер, 6 нийтлэл, 4 видеог иргэд, олон нийтэд хүргэсэн.





Зураг 22. Нийгмийн сүлжээгээр иргэдэд хүргэсэн зурагт хуудас, нийтлэлийн загварууд

Сайжруулсан түлшний зөв хэрэглээ, галлагааны аюулгүй байдлыг хангах зөвлөмж сэрэмжлүүлгийг 2019 оны 10, 11 дүгээр сард 2 удаа нийт давхардсан тоогоор 324849 айл өрхөд хүргэж 98%-ийн гүйцэтгэлтэй тус тус зохион байгуулсан. Мөн үүрэн телефоны хэрэглэгчдэд давхардсан тоогоор 7,504,615 багц мессеж илгээж, цаг үеийн болон сэрэмжлүүлэг мэдээллийг телевиз, цахим хуудсаар өдөр бүр, хэвлэлийн бага хурлыг олон нийтэд 7 хоногт 2 удаа хүргэж ажилласан.



Зураг 23. Сайжруулсан түлшний зөв хэрэглээ, галлагааны аюулгүй байдлын зөвлөмж

---

**Агаар бохирдуулагч эх үүсвэрийн цахим мэдээллийн санг ашиглан тухайн жилийн өөрчлөлтийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, өөрчлөлтийг бүртгэх ажлын хүрээнд:**

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 онд хэрэгжүүлэх “Гэр хорооллын нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналт, мониторинг, туршилт явуулах” арга хэмжээний хүрээнд нийслэлийн гэр хорооллын иргэдийн амьдрах орчны судалгааг дүүргүүдийн ЗДТГ, хороодтой хамтран хийж гүйцэтгэсэн. Судалгааг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэргийн гэр хороолол бүхий 95 хороодод 3902 хэсгийн ахлагч, орон тооны бус гэрээт ажилтнуудыг ажиллуулан 149789 өрхийн судалгааг авч нэгтгэн Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороонд хүргүүлсэн. Судалгааг ухаалаг гар утасны аппликейшн болон цаасан суурьтайгаар явуулж иргэдийн орон сууцны төрөл, дулаан алдагдал, халаалтаа шийдсэн хэлбэр, цахилгааны хэрэглээ, цахилгааны аюулгүй байдал, сайжруулсан зуух хэрэглэдэг эсэх, түлшний хэрэглээ, үнс болон хаягдлыг хэрхэн зайлуулдаг, жорлонгийн төрөл, тоо, хашаандаа бохирын цооногтой эсэх зэрэг амьдрах орчны мэдээ мэдээллийг цуглуулсан.

**Нийтийн тээврийн дизель автобусанд утааны тортог шүүгч DPF суурилуулах ажлын хүрээнд:**

Япон Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны "ЖАЙКА" байгууллага, Зам, Тээвэр хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран 2017 оны 09 дүгээр сарын 22-ний өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд “Нийтийн тээврийн автобусанд дизелийн тортгийн шүүлтүүр DPF (Diesel Particulate Filter) тоноглол суурилуулж утааны РМ ялгарлын бууралтыг турших төсөл” хэрэгжүүлсэн. “Зорчигч тээврийн нэгтгэл”, “Зорчигч тээвэр гурав”, “Сутайн буянт” гэсэн 3 компанийн их багтаамжийн нийт 24 автобусанд дизель хөдөлгүүрийн тортгийн шүүлтүүр DPF (MoCobee CT-3 загвартай) болон иж бүрдлийг Япон Улсын жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжаар буюу үнэ төлбөргүй суурилуулж 2018 оны 07 сараас эхлэн 1 жилийн хугацаанд хийж DPF төхөөрөмжийг суурилуулж хэрэглээнд нэвтрэх боломжтой болохыг баталгаажуулж 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Улаанбаатар хотод хүлээлгэн өгсөн. Дээрх төслийн хугацаанд өдөрт дунджаар 1 автобуснаас шүүгдэж буй РМ-ын хэмжээ 181 грамм буюу төсөл хэрэгжсэн нийт 11 сарын хугацаанд 585.2кг РМ-ыг шүүсэн дүнг гарсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг НТГ, БНСУ-ын Аж үйлдвэр, худалдааны яамны харьяа Гадаад худалдааны Төлөөлөгчийн газар "КОТРО УЛААНБААТАР ГХГГ" харилцан тохиролцож тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааны хэмжээг бууруулах шүүлтүүр суурилуулах санамж бичгийг 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд Нийслэлийн Тээврийн үйлчилгээний газраас Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ "Эй Эм Эм Жи" ХХК-тай хамтран БНСУ-ын CERAKOM компанид үйлдвэрлэсэн дизель хөдөлгүүрээс ялгарах хорт утаа шүүгч "HUBRID" DPF, "ACTIVE" DPF төхөөрөмжийг БНСУ-д 2009 онд үйлдвэрлэсэн DEAWOO BS-106 маркийн их багтаамжийн 5 автобусанд суурилуулж туршилтын ажил 2018 оны 11-р сараас эхлэн хийгдэж байна. Уг ажлын хүрээнд "Эй Эм Эм Жи" ХХК-иас туршилт судалгааны тайлан, хэмжилтийн дүнг хүлээн авч үзэхэд "HUBRID" DPF нь РМ тортогжилтийг 93.2 хувь, "ACTIVE" DPF нь РМ тортогжилтийг 79.6 хувь шүүсэн дүнтэй үргэлжилж байна.



---

### **Хяналт-шалгалт, судалгааны ажлын хүрээнд:**

Автомашингүй өдрийн хэмжилт Нийслэлд “Улаанбаатар марафон”-ийг тэмдэглэх хөтөлбөрийн хүрээнд “Авто машингүй өдөр”-ийг зохион байгуулах зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 18- ний өдрийн 07:00-18:00 цагийн хооронд автозамын хөдөлгөөнийг түр хугацаагаар хаах болсонтой холбогдуулан зам хаасан цэгүүдэд, тухайлбал: Ялалтын талбай, МУИС, Зүүн 4-н зам орчим, Баруун 4-н зам орчим нийт дөрвөн цэг дээр орчны агаарын бохирдлын хэмжээг тогтоож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнт үетэй харьцуулсан хэмжилтийг хийлээ.



*Зураг 24. “Автомашингүй өдөр”-ийн хэмжилтийн үеийн зураг*

Хэмжилтээр автомашинтай өдөр бүх цэгүүд дээр авто машингүй өдрийн утгаас  $\text{NO}_2$ -азотын давхар ислийн агууламж 4-7 дахин,  $\text{SO}_2$ -хүхрийн давхар ислийн агууламж 4-20 дахин давсан үзүүлэлттэй байгаа нь тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас замын дагуух орчинд ихээхэн хэмжээгээр хаягддаг болохыг харуулж байна.  $\text{PM}_{10}$  тоосонцрын хувьд авто машингүй өдөр энгийн үеийнхээс 1 -1.8 дахин бага,  $\text{PM}_{2.5}$  тоосонцрын хувьд авто машингүй өдөр энгийн үеийнхээс 1.3-1.8 дахин бага байв.

Нийслэлийн Багахангай дүүргийн 2019 оны 03 сарын 12-ны өдрийн 3/167 дугаартай албан хүсэлтийн дагуу Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр Засаг Даргын Тамгын газрын орчинд 2019 оны 05 дугаар сарын 7- 8-ний өдрүүдэд 24 цагийн турш орчны агаарын чанарт хэмжилт хийсэн. Хэмжилтээр  $\text{PM}_{2,5}$  тоосонцрын агууламж стандартаас хэмжээнд,  $\text{PM}_{10}$  тоосонцрын агууламж стандартаас 1,7 дахин өндөр хэмжигдсэн.



*Зураг 25. Багахангай дүүрэгт орчны агаарын чанарын хэмжилт хийж байгаа нь*

### Уурын болон халаалтын зуухны хэмжилт:

Нийслэлийн төвийн 6-н дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа халаалтын зуух эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр 41 зууханд хаягдал утааны хийн хэмжилт хийсэн. Хэмжилтийн өгөгдөлүүдийг MNS 5043:2016, NNS 5919:2008 стандарттай харьцуулсан дүнг гаргаж, мэдээллийн санд нэгтгэсэн. Хэмжилт хийсэн халаалтын зуухны 14 нь MNS5043:2016 стандартын шаардлагыг хангасан бол 27 хангаагүй үзүүлэлттэй байна.

100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалалтын болон уурын зуух эзэмшигч 90 аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зууханд хаягдал утааны хэмжилт хийж, хэмжилтийн орлого 23.1 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэв.

Хэмжилт хийлгэсэн аж ахуйн нэгж байгууллагуудын 37 нь MNS5043:2016 стандартын шаардлагыг хангасан бол 53 нь хангаагүй байна.

Хүснэгт 7. Усан болон халаалтын зуухны хаягдал утааны хэмжилтийн дүн (2019 оны 01-р сараас 12 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд хийсэн хэмжилт)

№	Зуух эзэмшигч байгууллагын нэр	УХЗ-ны нэр, хүчин чадал	Хаяг, байршил	Бохирдуулагч бодис /мкг/м3/-ээр				Эко тоноглол	Нүүрсний төрөл
				SO <sub>2</sub>	NO <sub>x</sub>	CO	TSP		
1	Эм СиЭс Кока Кола ХХК 1-р зуух	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригч	НН
		DZL-6т/ц	БЗД Үйлвэрийн байранд	229	81	836	342		
2	Эм СиЭс Кока Кола ХХК 2-р зуух	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригч	НН
		DZL-6т/ц	БЗД Үйлдвэрийн байранд	1335	366	1975	704		
3	Азийн хүүхдүүд цэцэрлэг	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	НН
		НРЖ 0,25МВт	СХД-7 хороо	366	168	4856	5361		
4	"Анун сервис" ХХК 42-р сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	БН
		Карборобо т-0,3 МВт	СХД-2 хороо Толгойт	2178	266	7488	7660		
5	"Анун сервис" ХХК 49-р сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон	БН
		Карборобо т-0,3 МВт	ЧД-15-р хороо	2208	220	3278	1055		
6		MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан	БН

	“Анун сервис” ХХК 67-р сургууль	Карборобо т-0,3 МВт	СХД 7-р хороо	220	25	840	120	даехар шүүлтүүр	
7	“Анун сервис” ХХК 72-р сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон	БН
		Экоэфек т -0,6 МВт	ЧД 15-р хороо	2165	207	4227	577		
8	“Анун сервис” ХХК 105-р сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан даехар шүүлтүүр	НН
		Экоэфек т -0,6 МВт	СХД 32-р хороо	2165	242	3853	318		
9	“Анун сервис” ХХК 107-р сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	БН
		Экоэфек т -0,6 МВт	СХД 2-р хороо	2294	246	3305	1392		
10	“Арцат вүүд” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон	БН
		Китурами 0,25МВт	ХУД 10-р хороо	316	331	2553	1256		
11	“Витсамо” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Хуурай үнс байригчтай	НН
		DZL 1,4МВт	БЗД 10-р хороо	886	548	1967	329		
12	“Живэртийн оргол” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	БН
		DZL 1,2МВт	ХУД 13-р хороо	120	55	5758	438		
13	“Ихэр шарангад” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Байхгүй	БН
		DZL 1,25МВт	СХД 32-р хороо	195	114	4063	3721		
14	“Модкон” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	НН



		Китурами 20кВт	ХУД үйлдвэрийн байранд	189	55	9333	1816		
15	"Молор трейд" ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Байхгүй	НН
		DZL 1,25МВт	СБД 19- хороо	1307	179	10233	779		
16	"Мөнхбаясах кейсине" ХХК	MNS5043:2016		800	450	5000	600		БН
		WSG 0,25МВт	СХД-31-р хороо	1825	173	5153	690		
17	"Оптимум прогресс"	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		НРЖ- 0,15МВт	СБД 19-р хороо	426	159	2942	803		
18	"Промон трейд" ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		СҚД СҚД- 0,15МВт	СБД 19-р хороо	656	156	4231	113		
19	Ану сервис ХХК  35 сургууль	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон усан давхар шүүлтүүр	НН
		Карборот 0,3МВт	СБД 14-р хороо	553	60	3341	340		
20	СХД-ийн ХХҮХ	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		УХЖЗ 0,04МВт	СХД 5-р хороо	38	88	31408	1107		
21	"Төгс бүтээмж" ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Циклон болон усан давхар шүүлтүүр	НН
		DZL 1.4МВт	СХД	625	206	7157	1129		
22	"Түмэн шувуут" ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		Прометей ХХК 0,25МВт	ХУД 8-р хороо	366	153	1392	3890		

23	“Тэмүүлэн од” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	байхгүй	БН
		WSG-0.25MBm	БЗД 9-р хороо	801	296	1985	1087		
24	“УБ буян” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		LSG 0.18MBm	СХД	272	15	3083	679		
25	“Цоба пропертиз” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		МУХТ 0,5MBm	СБД-14-р хороо	1322	264	1756	309		
26	“Шаб” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Циклон болон усан давхар шүүлтүүр	АТ
		DZL 1,25MBm	СБД 18-р хороо,	1083	250	297	176		
27	“Шилэн хийц” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		USPOR 0,09MBm	СХД	1209	291	3714	480		
28	“Эм Жи Эл Акуа” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Циклон болон усан давхар шүүлтүүр	БН
		CWSN 0.7 MBm	СХД-ийн 7-р хороо	1838	237	2432	2904		
29	“Эрдэнэбулаг хуяг” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		LS60 0.056 MBm	БЗД 14-р хороо Нарантуул захын урд	375	202	7165	315		
30	“Монгол эко мах” ХХК	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		DZH1 0,7MBm	СХД 32-р хороо	27	60	1569	173		
31	“Эс Эс Си Монголиа Фүүд” ХХК	MNS5919:2008		1500	680	940	8000	байхгүй	НН
		УХЖЗ 0,12MBm	СХД	100	22	223	107		

		Хятад	32-р хороо						
32	“Саян Уул” ХХК	MNS5919:2008		1630	1500	4100	13000	байхгүй	АТ
		DZH3 1,25MВт	СХД 31-р хороо	36	20	7973	107		
33	Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төв	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	БН
		БЗИУ 1 MВт	БЗД 9-р хороо	107	40	356	956		
34	ДТҮЭХ	MNS5043:2016		800	450	5000	600	байхгүй	НН
		ДТХ 0,35MВт т	СБД 19-р хороо	32	20	3256	215		
35	Эс Эс Си монголиа фүүд	MNS5919:2008		680	1500	9400	8000	Нойтон үнс баригчтай	НН
		DZC1 1тн/ц	СХД 32-р хороо	31	100	223	107		
36	Эсу	MNS5919:2008		680	1500	9400	8000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	121	109	960	732		
37	Монгол Эко Мах	MNS5043:2016		800	450	5000	600	Нойтон үнс баригчтай	БН
		DZH1 0.7MВт	СХД 32-р хороо	60	27	1569	173		
38	Арцат Вүүд	MNS5043:2016		450	800	5000	600	байхгүй	НН
		Китура ми 0,25MВт т	ХУД 10-р хороо	331	316	2553	1256		
39	Саян уул	MNS5043:2016		1500	1630	4100	13000		АН

		DZH3 1тн/ц	СХД 31-р хороо	272	433	2694	215	Нойтон үнс баригчтай	
40	Эрчис тал	MNS5919:2008		1500	680	9400	8000	Циклон болон шүүлтүүр	АН
		DZH1 1тн/ц	СХД 20-р хороо	237	64	365	334	Давхар шүүлтүүр	
41	СЭМУТ	MNS5043:2016		800	450	5000	600	Циклон болон шүүлтүүр	БН
		БЗИУ 1МВт	БЗД 9-р хороо	107	40	356	956	Давхар шүүлтүүр	
42	ЖЭЙ ТИ ЭС ЭС	MNS5919:2008		1500	680	9400	8000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	57	121	1243	983		
43	Цогш	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	103	103	845	1344		
44	Иннова	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	103	107	1514	1344		
45	Женерал эталон	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	1750	103	1500	1344		
46	Өргөө мийт	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	103	103	1514	1344		
47	Дун Фан Интернэйш нл	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	346	39	195	1029		
48	Цэн манхан	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	217	49	55	2565		

49	Хатан Интернэшн л	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	106	33	46	807		
50	Керано	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	103	103	1514	1344		
51	Дөлгөөн барс	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	1751	64	776	768		
52	Мөнх баясах кейс	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		2тн/ц	СХД 32-р хороо	518	423	371	477		
53	Мон-Арк	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Нойтон үнс баригчтай	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	193	400	592	304		
54	Цан Сэн Тиан Ий	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	834	287	258	1424		
55	Ариун Булаг Интернэшнл	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	851	137	1115	1572		
56	Шилүүст сүмбэр	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	1219	344	1885	2188		
57	Үүлэн гөү	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		DZH2 2тн/ц	СХД 20-р хороо	1012	347	1872	989		
58	Энхтэд	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	НН
		DZL2 2тн/ц	СХД 20-р хороо	132	68	712	872		
59	"Жэй Эйч Жэй	MNS5919:2008		1620	1150	1030	12000		НН




	Мандухай” ХХК	DZL2 2тн/ц	СХД 20-р хороо	1529	409	1001	1833	Багц циклон хуурай үнс баригч	
60	“Жи Эс Дорнын Хөгжил” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Хуурай үнс баригчтай	ТТ
		SZL 8тн/ц	СХД 32-р хороо	3048	776	2782	1814		
61	“Мөнх төгрөг” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	НН
		DZL 2тн/ц	БЗД 11-р хороо	1260	760	776	1513		
62	“Тэлмэн Ану” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		CZG1 2тн/ц	СХД 32-р хороо	1529	348	1015	1947		
63	“Сайн цаас” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Хуурай үнс баригчтай	НН
		DZL4 4тн/ц	СХД 20-р хороо	672	599	1863	2051		
64	“Ганган анд” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Хуурай үнс баригчтай	АТ
		LSH 0.5- 0.7тн	СХД 20-р хороо	802	528	1785	3028		
65	“Оптималь” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	НН
		DZL 8тн/ц	СХД 32-р хороо	1014	184	918	435		
66	“Ашика” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		HP06Ж	ХУД 14-р хороо	645	233	1497	455		
67	“Мон грийн хас” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	НН
		DZL7 7тн/ц	СХД 32-р хороо	934	473	7141	1985		
68	“Дужин” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		Зуан Чи 0.5 тн/ц	СХД 20-р хороо	672	198	8958	6014		

69	“Трансбус” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Нойтон үнс баригчтай	БН
		CWSHO	БЗД 8-р хороо	782	325	16155	613		
70	Трансбус” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Нойтон үнс баригчтай	БН
		CWSHO	СХД 24-р хороо	1469	371	23338	514		
71	“Амгалан Ложистик” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	АТ
		XT 600	БЗД 10-р хороо	610	300	2785	340		
72	“Жапан Монглиан Фриэндип” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		HP06Ж	СХД 17-р хороо	412	363	4497	560		
73	“М Би Си Азиа Пасифик” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	НН
		DZL 8тн/ц	СХД 32-р хороо	1602	184	1584	1345		
74	“Хуамейда” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Хуурай үнс баригч	БН
		LSG	БЗД 10-р хороо	785	186	3515	896		
75	“Мегаүүд” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	АТ
		Мегаүүд	БЗД 10-р хороо	610	294	2785	583		
76	“Проджи” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Нойтон үнс баригчтай	БН
		Ekostar S300	Хан-Уул 10-р хороо	133	165	7723	340		
77	“Агро нэгтгэл трейд” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Байхгүй	АТ
		ОПОП 90D	СХД 32-р хороо	1601	446	822	661		
78	“Мөнх дөлгөөн тэнгис” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	АТ
		CLSG-1200	СХД 32-р хороо	1618	371	2779	3105		
79	“Эмээлт эрдэнэ трейд” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	ТТ
		LSS 0.5 тн/ц	СХД 26-р хороо	411	182	1457	1161		


80	Иргэн Шийрэв дамба	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	ТТ
		GLSG1 1тн/ц	СХД 32-р хороо	753	391	2489	1030		
81	“Нүүр ам судлалын төв” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	БН
		ДоП	СХД 32-р хороо	52	481	638	492		
82	“Мянган лант холдинг” ХХК	MNS 5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		DZL 2тн/ц	Налайх 6-р хороо	1430	776	954	914		
83	“Нүхт” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		CZML	ХУД 4-р хороо	771	212	2521	812		
84	“Очир орд” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	БТН
		HP-16Ж	ЧД 13-р хороо	617	405	5187	381		
85	“Анко” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Нойтон үнс баригчтай	БН
		GZZ-0137	ЧД 12-р хороо	545	215	6916	439		
86	“SAFE TRACK” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		SKHGL	БЗД 24-р хороо	412	146	2950	624		
87	“Жавхлант дэлгэр хангай” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		LSG 0.5тн/ц	СХД 32-р хороо	314	184	2647	368		
88	“Стандарт шуудай” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	АТ
		DZL 4тн/ц	СХД 33-р хороо	825	170	2121	544		
89	“Ди Эйч Ти Эн” ХХК	MNS5919:2008		1620	1150	1030	12000	Багц циклон хуурай үнс баригч	БН
		DZL 2тн/ц	СХД 33-р хороо	1305	237	1608	734		
90	“Чингис хааны хүрээ” ХХК	MNS 5043:2016		800	450	5000	600	Багц циклон хуурай үнс баригч	НН
		Монгол зуух	Хан-Уул 8-р хороо	496	159	4083	615		

MNS5043:2016, MNS 5919:2009  
 стандартыг хангаагүй зуухны  
 байгууламжын тоо


53 зуух буюу 58.8%



Зураг 26. Усан халаалтын зуухнуудын тоосонцор /TSP/- ын агууламжийн хэмжээ




Зураг 27. Усан халаалтын зуухнуудын хүхрийн давхар исэл /SO<sub>2</sub> /-ийн агууламжийн хэмжээ




Зураг 28. Усан халаалтын зуухнуудын Нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/-ийн агууламжийн хэмжээ





Зураг 29. Уурын зуухнуудын тоосонцор /TSP/-ын агууламжийн хэмжээ



Зураг 30. Уурын зуухнуудын нүүрстөрөгчийн дутуу ислийн /CO/ агууламжийн хэмжээ

Төвийн 6 дүүргийн 16-100кВт хүртэлх хүчин чадалтай 2397 усан халаалтын зуух эзэмшигчдэд зөвлөмж мэдэгдэх хуудсыг дүүргүүдийн Засаг даргын тамгын газарт 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02/232 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд Баянзүрх дүүрэг-507, Сонгинохайрхан дүүрэг-450, Чингэлтэй дүүрэг-120, Баянгол дүүрэг-300, Хан-Уул дүүрэг-328, Сүхбаатар дүүрэг-306, нийт-2011 мэдэгдэх хуудсуудыг 16-100кВт хүртэлх хүчин чадалтай усан халаалтын зуухтай аж ахуй нэгж байгууллагад

хүргүүлж, түүхий нүүрс хориглох тухай 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сурталчлан хяналт тавьж ажилласан.

2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өгсөн үүрэг даалгаварын хүрээнд “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс болон дүүрэг хороодод хяналт шалгалт хийх удирдамж”-ийг Агаар орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д. Мөнхжаргалаар батлуулан 2019 оны 6 дугаар сарын 18-19-ны хооронд Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, дүүрэг, хороодын холбогдох мэргэжилтэн, байцаагч нар ажиллалаа. БЗД, БГД, ЧД, ХУД, СХД, СБД-ийн нийт 33 хорооны 45 айл өрх, 28 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн 57 албан шаардлага өгч, 11 янданг буулган ажиллав.



*Зураг 31. Агаарын чанарыг сайжруулах 4 дүгээр бүсэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах үйл ажиллагаа*

ЗГ-ын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих ажлын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга Н.Цэрэнбат, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан нарын хооронд гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлтэд хяналт тавих 4 түвшний 4208 хүнээс бүрдсэн хяналтын багийг 7 сарын хугацаатайгаар ажиллуулж байна.

Түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичигт хяналт тавих ажлын хүрээнд хүрээнд нийслэлийн Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороодод түүхий нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгож байгаа болон тэдгээрийн хэрэгжилт, явц, үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлтийг боловсруулж, удирдлагуудыг мэдээллээр хангах зорилготой Улаанбаатар хотын ерөнхий менежер Т.Гантөмөрийн даргын баталсан удирдамжийн дагуу 2019 оны 10 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Вагон тээвэрлэлт хийж байгаа “Багануур илч” ХХК-ийн Баянгол дүүрэг дэх “Санби” ХХК-ийн нүүрс олголтын цэг дээр хийсэн хяналт шалгалтаар Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны 5 ширхэг зөвшөөрлийн бичгийг бичилт хийгээгүй, олгосон байгууллагын таславч таслаагүй бөгөөд таславчийг таслаж баримтандаа үдсэн зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн.

2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Эмээлт, Өлзийтийн 1, 2 дугаар постуудаар хяналт шалгалт хийж ажилласан. Постуудаар хяналт шалгалт хийх явцад хяналтын

ажилтнууд бүртгэл дутуу, тонн жин зөрсөн, эрх бүхий ажилтан олгоогүй гэсэн зөрчлүүд байгаа талаар мэдээлэл өгсөн.

**Сайжруулсан хатуу түлш Техникийн шаардлага MNS 5679:2019 стандартын шаардлага хангаж буй эсэхэд тогтмол хяналт тавих**


Түүхий нүүрсний хэрэглээг хориглох тухай Монгол улсын засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолтой холбоотой сайжруулсан түлш үйлдвэрлэж байгаа хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу сайжруулсан шахмал түлшний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн стандартын шаардлага хангаж буй эсэхэд хаягдал утааны хийн хэмжилт хийж ажиллаж байна.

Хүснэгт 8. “Таван толгой түлш” ХХК-ний үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшний хэмжилт хийсэн дүн /Ахуйн хэрэглээний зуух, техникийн ерөнхий шаардлага MNS 5216:2016/


№	огноо	Нийт тоос (TSP)мг/нм <sup>3</sup>	Хүхрийн давхар исэл (SO <sub>2</sub> )мг/нм <sup>3</sup>	Азотын исэл (NO <sub>x</sub> )мг/нм <sup>3</sup>	Нүүрстөрөгчын дутуу исэл (CO)мг/нм <sup>3</sup>
	<b>MNS:5216.2016 стандарт</b>	<b>130</b>	<b>1200</b>	<b>700</b>	<b>9800</b>
1	2019/6/3	139	1133	409	8476
2	2019/6/4	74	1206	339	5366
3	2019/6/10	100	1429	481	9584
4	2019/6/12	172	1291	427	8021
5	2019/6/17	134	1048	432	7435
6	2019/6/18	97	1115	361	6233
7	2019/6/19	120	1210	349	7879
8	2019/6/20	101	1366	379	7751
9	2019/6/25	52	709	338	6668
10	2019/8/14	116	1007	446	5432
11	2019/8/15	131	1061	335	3376
12	2019/8/19	138	1000	318	4311
13	2019/8/20	69	657	318	2620
14	2019/8/21	272	723	341	5028
15	2019/8/28	132	368	424	5703

16	2019/11/09	210	754	406	14553
17	2019/11/20	488	768	385	6048


Тайлбар: Улаан өнгөөр стандартаас давсан үзүүлэлтийг тэмдэглэв.



Зураг 32. Таван толгой түлш ХХК-ний сайжруулсан түлшнээс ялгарах тоосны хэмжээ



Зураг 33. Таван толгой түлш ХХК-ний сайжруулсан түлшнээс ялгарах хүхрийн давхар ислийн хэмжээ



Зураг 34. “Таван толгой түлш ХХК”-ний сайжруулсан түлшнээс ялгарах нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжээ

НАБТГ-ын зуухны лабораторийн Дөл зууханд 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд хийсэн сайжруулсан түлшний хэмжилтийн дүн.

Жич: Агаар бохирдуулах бодисын агууламжийг утааны хий дэх хүчилтөрөгчийн хэмжээг 10% байхаар хэвийн нөхцөлд шилжүүлэн тооцсон дүн, нийт 17 удаагийн хэмжилт хийгдсэнээс ахуйн хэрэглээний зуух, техникийн ерөнхий шаардлага MNS 5216:2016 стандартын шаардлага хангасан 4 хэмжилт байна.

“Жайка” төслийн мэргэжилтүүдийн хамт 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийтдээ “Баялаг эрдэнэ цом” ХХК-ийн үйлдвэрлэсэн биомасс, сайжруулсан түлшний 16-н дээжинд хаягдал утааны хийн хэмжилт хийсэн байна. Үүнээс уламжлалт зууханд 6 удаа, “Дөл” зууханд 10 удаагийн хэмжилт хийж өгөгдөлүүдийг тус тус боловсруулж хэмжилтийн дүнг “Ахуйн хэрэглээний зуухны техникийн ерөнхий шаардлага, яндангаас гарах утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга” MNS 5216:2016 стандарттай харьцуулан дүнг танилцуулсан.



Зураг 35. Нүүрсэн шахмал түлш

Биомасс



## Хүснэгт 9. Сайжруулсан хатуу түлшний шинжилгээ

### 1.1. Техникийн үзүүлэлт

№	Түлшний төрөл	Чийглэг (W <sub>a</sub> )%	Нийт хүхэр (S <sup>t</sup> )%	Дэгдэмхий бодис (V <sup>d</sup> )%	Үнслэг A <sup>d</sup> %	Илчлэг (Q <sup>ad</sup> b) (ккал/кг)	Тайлбар
1.	MNS5679: 2019	≤10,00	≤1,00	≤22,00	≤29,00	≥4200	
2.	ТТТ-2	1,39	0,97	20,11	23,20	6343	“Таван толгой түлш”ХХК-аас ирүүлсэн шинжилгээний дүн НМХГ-аас ирүүлсэн шинжилгээний дүн “Жайка” ОБГ-ын зүгээс хийлгүүлсэн шинжилгээний дүн
3.	ТТТ-БЦ	-	2,23	28,45	25,18	5875	
4.	ТТТ -3%	1,89	1,17	20,82	26,22	6086	
5.	M-Sno	2.73	0.87	19.58	22.98	6244	
6.	M-S	2.35	0.74	21.12	21.67	6331	

Тайлбар: ТТТ-Таван толгой түлш ХХК, БЦ- борлуултын цэгээс ирсэн дээж, 3%-3 хувь хүхэр саармагжуулагч хольсон, M-S – хүхэр саармагжуулагч хольсон миддлинг брикет 3 см-ын голчтой, M-Sno-миддлинг брикет хүхэр саармагжуулагчгүй. M-S түлшийг “Жайка” ОБГ-ын зүгээс захилгаар үйлдвэрлүүлсэн түлш.

### 1.2. Экологийн үзүүлэлт

Ахуйн хэрэглээний зуух техникийн ерөнхий шаардлага MNS 5216 : 2016 стандарт нь Стандартчилал, хэмжилзүйн үндэсний Зөвлөлийн 2016 оны 11-р сарын 24- ны өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2017 оны 4- р сарын 1- ны өдрөөс эхлэн хүчинтэй. (Агаарын чанарыг сайжруулах бүсийн иргэд тус стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн хэрэгтэй.)

Хүснэгт 10.


№	Түлш	Нийт тоосонцор, (TSP) мг/нм <sup>3</sup>	Хүхрийн давхар исэл, (SO <sub>2</sub> ) мг/нм <sup>3</sup>	Тайлбар
1.	MNS 5216 : 2016 стандарт	≤130	≤1200	Стандартад түлш ноцох хугацааг заадаггүй.
2.	ТТТ-2	172	1291	Түлш ноцооход хүндрэл гараагүй.
3.	ТТТ-БЦ	134	1048	Түлш ноцооход хүндрэлтэй.
4.	ТТТ -3%	101	1366	Түлш ноцооход хүндрэл гараагүй.
5.	M-Sno	74	1206	Түлш харьцаагүй хурдан ноцсон.
6.	M-S	117	959	

### 1.3. Хэрэглээний үзүүлэлт

Хүснэгт 11.


№	Түлш	Шаталтын үеийн температур				Үнс гаралт (5 кг түлш)	
		Мин, °C	Макс, °C	300°C хүрэх хугацаа, минут	300°C дээш үргэлжлэх хугацаа, минут	%	кг
1.	ТТТ-2	166	335	19	173	34	1.7
2.	ТТТ-БЦ	116	379	33	110	35	1.75
3.	ТТТ -3%	200	385	26	110	40	2
4.	M-Sno	288	436	2	155	36	1.8
5.	M-S	262	413	7	140	-	-

Жич: Шаталтын үеийн температур гэдэг нь зуухны хүхээгнээс дээш 1м орчим дахь яндангийн доторх утааны температур юм.



**Зураг 36. Таван толгой түлш ХХК-ийн сайжруулсан хатуу түлшний ноцох хугацаа**

Түлшний ноцож эхлэх буюу асаж эхлэх хугацаанд хамгийн их тоосонцор ялгаруулдаг бөгөөд энэ нь “Таван толгой түлш” ХХК-ийн түлшний хувьд 19-33 минут байна.



**Зураг 37. Япон Улсын “ЖАЙКА” ОУБ-ын зүгээс захиалгаар үйлдвэрлүүлсэн түлш**

Япон Улсын “ЖАЙКА” ОУБ-ын зүгээс захиалгаар үйлдвэрлүүлсэн түлшний ноцож буюу асаж эхлэх хугацаа 2-7 минут байна.

#### 1.4. Түлшний хэмжээ



**Зураг 38. “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ийн сайжруулсан хатуу түлш нь 50 мм голчтой бөгөөд 30 мм-ийн зузаантай. 1 бүрийн жин 45 грамм.**

Япон Улсын “ЖАЙКА” Олон улсын байгууллагын зүгээс захиалгаар үйлдвэрлүүлсэн түлш нь 30 мм голчтой бөгөөд 20 мм-ийн зузаантай. 1 бүрийн жин 35 грамм.

- Сайжруулсан хатуу түлшний техникийн стандарт үзүүлэлтийн хувьд “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ийн борлуулалтын цэгээс авснаас бусад буюу үлдвэрээс ирүүлсэн түлш MNS5679:2019 стандартыг хангаж байна.
- “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ийн түлш шаталтаас ялгарах экологийн стандарт шаардлагыг хангахгүй байна. ТТТ-2; ТТТ -3% түлшнүүд нь ноцооход хүндрэлгүй ассан нь хүхрийн давхар исэл (SO<sub>2</sub>)-д тавигдах стандарт шаардлагаас давсан байна. ТТТ-БЦ түлшний хувьд түлш ноцох хугацаа хамгийн их байсан нь тоосонцрын хэмжээ стандарт шаардлагаас их гарсан мөн нөгөөтэйгүүр түлшний шаталтын үеийн 300<sup>0</sup>С дээш үргэлжлэх хугацаа бага байгаа нь хүхрийн шатаж исэлдэх нөхцөл бүрдээгүйгээс хүхрийн давхар исэл бага үүссэн гэж үзсэн. Учир нь түлшний техникийн үзүүлэлтэд хийсэн шинжилгээгээр хүхрийн агууламж 2,23% буюу бусад түлшнүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байна.
- “ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК-ийн түлшний хэрэглээний түвшинд шинжилгээ хийж үзэхэд шаталтын үеийн температур Япон Улсын “ЖАЙКА” Олон улсын байгууллагын зүгээс захилгаар үйлдвэрлүүлсэн түлшнээс бага байна.

Байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд агаарын чанарын хяналт тавих ажлын хүрээнд барилга, авто засвар, угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж “Эко авто моторс” ХХК “Их соёмбо” ХХК, “Перфект мотор” ХХК, “Эн Си Ди” ХХК-иудын орчинд агаарын чанарын хэмжилт хийсэн.

Хүснэгт 12. Хэмжилтийн дүн  
Ривер гарден хотхон

Төлөв	PM <sub>2,5</sub>	PM <sub>10</sub>	SO <sub>2</sub>
	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>
Өглөө 9:05-10:05	7	8	15
MNS 4585:2016	7,1 дахин бага	12,5 дахин бага	3.3 дахин бага
Орой 16:13-17:14	11,7	12	20
MNS 4585:2016	4,2 дахин бага	8,3 дахин бага	2,5 дахин бага

Гарден сити хотхон

Төлөв	PM <sub>2,5</sub>	PM <sub>10</sub>	SO <sub>2</sub>
	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>
Өглөө 9:05-10:05	178	182	54
MNS 4585:2016	3,5 дахин их	1,8 дахин их	Стандарт хэмжээнд
Орой 16:34-17:34	12	14	3
MNS 4585:2016	4,1 дахин бага	7,1 дахин бага	16,6 дахин бага

Каса да винчи хотхон

Төлөв	PM <sub>2,5</sub>	PM <sub>10</sub>	SO <sub>2</sub>
	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>
Өглөө 08:37-937	136	139	37
MNS 4585:2016	2,7 дахин их	1,4 дахин их	1,4 дахин бага
Орой	27	29	16
MNS 4585:2016	<b>1,9 дахин бага</b>	<b>3,5 дахин бага</b>	<b>3,1 дахин бага</b>

Хан-уул дүүргийн 6 дугаар хороо гэр хороолол дунд

Төлөв	PM <sub>2,5</sub>	PM <sub>10</sub>	SO <sub>2</sub>
	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>	мкг/м <sup>3</sup>
Өглөө	172	176	49

MNS 4585:2016	3 дахин их	1,8 дахин их	Стандарт хэмжээнд
Орой 16:33-17:33	26	28	12
MNS 4585:2016	1,9 дахин бага	3,6 дахин бага	4,1 дахин бага

**100кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд магадлан итгэмжлэл явуулах, 100 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухнаас ялгарах үнс, тоосонцрын хэмжээг бууруулах ажлын хүрээнд:**

2018-2019 оны халаалтын улиралд Нийслэлийн төвийн 9 дүүргийн хэмжээнд 101кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуухны магадлан итгэмжлэх ажлын удирдамжийг боловсруулан НЗД-ын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогчоор батлуулсан.

Хяналт, шалгалт хийж магадлан итгэмжлэх ажлыг 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 01-нийг хүртэлх хугацаанд хийгдсэн. Тус ажлын хүрээнд БЗД-ийн 101 кВт-аас дээш хүчин чадалтай 65 аж ахуйн нэгжийн 142 зуух, БГД-ийн 10 аж ахуйн нэгжийн 12 зуух, ХУД-ийн 35 аж ахуйн нэгжийн 67 зуух, СХД-ийн 42 аж ахуйн нэгжийн 83 зуух, СБД-ийн 28 аж ахуйн нэгжийн 53 зуух, ЧД-ийн 25 аж ахуйн нэгжийн 49 зуух, Багануур дүүргийн 1 аж ахуйн нэгжийн 1 зуух, Багахангай дүүргийн 2 аж ахуйн нэгжийн 10 зуух, Налайх дүүргийн 9 аж ахуйн нэгжийн 34 зуух нийт 217 аж ахуйн нэгжийн 451 зууханд хяналт шалгалтыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөл, Хэсэгчилсэн Инженер хангамжийн удирдах газар, дүүргүүдийн ЗДТГ -тай хамтран хийсэн.

**Магадлангийн ажлын үр дүн:** Нийслэлийн төвийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын шалгалтаар мэргэжлийн байгууллагаар угсарч суурилуулсан, туршсан актгүй, үнс баригч тоног төхөөрөмжөөр тоноглоогүй, орчиндоо үнс, хог хаягдал хуримтлуулсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй зэрэг холбогдох баримт бичиггүй зөрчлүүд илэрч байна. Илэрсэн зөрчлүүдийг үндэслэн 13 ААНБ-д Зөрчлийн хэрэг нээн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 22 ААНБ-д зөрчлийн хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, 1 ААНБ-д зөрчлийн хэрэг нээн татгалзаж, нийт 33 ААНБ-д 42 сая төгрөгийн торгууль ногдуулж, 44 ААНБ-уудад 129 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 33 ААНБ-д эрх бүхий албан тушаалтаны даалгавар өгч ажилласан байна.

Хүснэгт 13. Хяналт шалгалтанд хамрагдсан ААНБ-ыг зориулалтаар ангилсан байдал

Д/д	Зориулалт	Байгууллагын тоо	Зуухны тоо
1	Боловсролын газар	17	28
2	Эрүүл мэндийн газар	5	12
3	Цэрэг, цагдаа, шүүхийн байгууллага	24	73
4	Амралт сувилалын газар	13	23
5	Худалдаа үйлчилгээний газар	35	52
6	Үйлдвэрлэл үйлчилгээний газар	37	65
7	Зочид буудал, зоогийн газар	3	8
8	Орон сууцны газар	15	36
9	Хөнгөн блокны газар	7	8

10	Бусад	62	146
Нийт		<b>218</b>	<b>451</b>

Хамрагдсан 218 ААНБ-ын 451 зуухнаас 52.9 хувь нь үнс баригчтай бол, 47.0 хувь нь үнс баригчгүй байна. Үнс баригчийн тоон үзүүлтийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 14. ААНБ-ын зуухны үнс баригчийн талаарх судалгаа

Д/д	Дүүрэг	Нийт байгууламжийн зуухны тоо	Нойтон үнс баригч	Хуурай үнс баригч	Утаа шүүгч, катализатор	Байхгүй
1	Баянгол	12	4	3	2	3
2	Баянзүрх	137	11	37	6	83
3	Сонгинохайрхан	83	13	25	2	43
4	Сүхбаатар	53	4	23	-	26
5	Хан-Уул	67	24	35	2	6
6	Чингэлтэй	54	4	26	4	20
7	Багануур	1		1		
8	Багахангай	10		5		5
9	Налайх	34	8			26
<b>Нийт</b>		<b>451</b>	<b>68</b>	<b>155</b>	<b>16</b>	<b>212</b>



Зураг 39. 2018-2019 оны халаалтын улиралд хийгдсэн магадлан итгэмжлэлийн ажил

**Автотээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас ялгарах хорт хийн хяналтын ажлын хүрээнд:**

“Автотээврийн хэрэгслийн утааны яндангаас гарах дуу чимээ, ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ, дүгнэлт өгөх” удирдамжийг Замын цагдаагийн албаны дэд бөгөөд замын цагдаагийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч, Автотээврийн Үндэсний төвийн дэд захирал нараар батлуулан 2019 оны 07 дугаар сарын 11-ний өдрөөс энэ оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Автотээврийн хэрэгслээс ялгарах хаягдал утааны найрлага дахь хорт бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байгаа эсэхийг холбогдох стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд




---

үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор замын хөдөлгөөнд оролцож буй нийт 1500 орчим тээврийн хэрэгслийг хамруулсан. Тус арга хэмжээний хүрээнд Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар нийт 49 тээврийн хэрэгслийн жолоочид бэлэн бус торгуулийн шийтгэл ногдуулж, тухай бүр зөвлөмж хүргүүлж, холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллагад энэ төрлийн зөрчлийг арилгуулах талаар мэдэгдэл, шаардлага хүргүүлж ажилласан.

***Дотоод орчны агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:***

Нийслэлийн боловсролын газартай хамтран 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Хангарди ордны 15 цагт “Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах” чиглэлээр “Окфил” ХХК-нь цонхны агаар шүүгчийн талаар илтгэл тавьж бүтээгдэхүүнээ танилцуулсан.

НЗД-ийн 2017 оны 12 дугаар сарын 17-ны А/1005 тогтоол, захирамжаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, амаржих газруудад дотоод агаарын чанарыг сайжруулах зорилгоор 2017-2018 онд олгосон агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийн үйл ажиллагаа, ашиглалтын байдалд хэмжилт хийх ажлыг Газрын даргын удирдамжаар батлуулан ажиллалаа. Чингэлтэй дүүргийн 4, 33, 245, 74, 222, Сүхбаатар дүүргийн 135, 42, ХУД-ийн 209, 46, 12, СХД-ийн 259, 90, БЗД-ийн 201-р цэцэрлэгүүдийн агаар шүүгчийн ажиллагааны байдалд 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс 29-ны өдрүүдэд үзлэг, хэмжилт хийж, холбогдох зөвлөгөөг өгч ажиллаа.



*Зураг 40. Сургууль, цэцэрлэгүүдийн агаар цэвэршүүлэгч төхөөрөмжийн ажиллагаанд хяналт шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч байгаа нь:*

2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн Нийслэлийн ЕБС-ийн бүх сургуулиудад улирал бүрийн эхэнд агаарын бохирдлоос эрүүл мэндээ хэрхэн хамгаалах талаар сургалт зохион байгуулж байна.

Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах, дотоод орчны агаарын чанарыг сайжруулах чиглэлээр 200 гаруй постер, 5 кино, нэврүүлэг бэлтгэн твитер, пэйж, вэбсайтаар дамжуулан иргэдийн оролцоо, мэдлэг боловсролыг дээшлүүлэн ажиллаж байна.

---

### ***Мэдээлэл технологийн ажлын хүрээнд:***

Нийслэлийн агаарын чанарын суурин харуулын мэдээг цагт тухайд нь онлайнаар [www.agaar.mn](http://www.agaar.mn), [www.air.ub.gov.mn](http://www.air.ub.gov.mn), [www.aqicn.org](http://www.aqicn.org) сайтуудаар иргэдэд мэдээллэж байгаа бөгөөд суурин харуулын байршил бүрд LCD дэлгэцээр мөн БОАЖЯам, Хангарди ордон, ЦУОШГ-ын үүдэнд нийт 4 ТВ дэлгэцээр, мөн гар утасны “Агаар” аппликейшнээр дамжуулан олон нийтэд шууд хүргэж байна. Суурин харуулуудын мэдээлэл дамжуулах сервер, сүлжээний тохируулгыг холбогдох газруудаар цаг тухайд нь хийлгэж хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.

Албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглож байгаа талаар нийт албан хаагчдад танилцуулан интернет үйлчилгээг Хангарди ордны сүлжээгээр дамжуулан авч, олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй байх тохиргоог хийлгэсэн. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс бүх компьютерт “ESET End point” антивирусны программ хангамжийн лицензыг авч суулгасан.

НЗД-ын 2013 оны А477 дугаар захирамжаар батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлын журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон байгууллагын дотооддоо мэдээллийн аюулгүй байдлын журам боловсруулан Газрын даргын 2019 оны А/56 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна.

Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын төсөлд цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөхтэй холбогдох үүргийг тусгаад байна.

### ***Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлын хүрээнд:***

Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод 2019 оны 03 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Байкал трейд 2019” бизнес форумд Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгаланар ахлуулсан төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тус газрын мэргэжилтэн Г.Даваажаргал орж ажилласан. Форумын үеэр Бүгд Найрамдах Буриад Улсын Тэргүүн А.С.Цыденов албаны төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Буриад Улс нь Улаанбаатар хоттой хамтран агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр түүхий нүүрс түлж буй айл өрхүүдэд модон шахмал түлш нийлүүлэх боломжтой талаар ярилцсан болно.

Нийслэлийн ИТХ-ын дарга Р.Дагвын урилгаар БНСУ-ын Сөүл хотын ИТХ-ын дарга Шин Веон Чул тэргүүтэй төлөөлөгчид 7 дугаар сарын 10-наас 13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо айлчилсан. Айлчлалын үеэр нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын үйл ажиллагаатай танилцаж агаарын чанарыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах талаар ярилцаж, санал солилцсон.

### ***ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЖУУЛАЛТ, НИЙГМИЙН БАТАЛГАА:***

Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, сургалтын болон нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

**Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын хэрэгжилт**

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
<b>1. Хүний нөөцийг Чадавхжуулах</b>	1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	8 удаагийн сургалтад 19 албан хаагч хамрагдсан. 100%	Зохион байгуулагч байгууллага зардлыг хариуцсан.	
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	Давхардсан тоогоор 20 албан хаагч хамрагдсан 100%		
			Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	4 албан хаагч хамрагдсан. 100%		
	2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	Төрийн жинхэнэ албан тушаалд 11, төрийн үйлчилгээний албан тушаалд 18 албан хаагч нийт 29 албан хаагч ажиллаж байна. 80%		
Хэсгийн дундаж: 90%							
<b>2. Албан хаагч-дын Нийгмийн Баталааг хангах</b>	3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	Тэмдэглэлт баярын өдрийг тохиолдуулан 1 албан хаагч Алтан гадас одон, 1 албан хаагч "Нийслэлийн хөдөлмөрийн аварга" 14 албан хаагч Нийслэлийн 380 жилийн ойн медиалаар шагнагдсан. 90%		
			Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	1 албан хаагчид удан жилийн нэмэгдэл, 2 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл олгосон 100%		
	4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Нийт албан хаагчдыг өвлийн хос ажлын хувцсаар хангаж, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай 4 үйлдэлтэй принтер, хувилагч зэрэг 4 ширхэг техник тоног төхөөрөмжийг шинээр худалдан авсан. 90%		

		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	Албан хаагч бүрт сар тутам унаа, хоолны зардал 121000 төгрөг олгож байна. 100%	/13,392, 000 төгрөг/ Нийт албан хаагчийн жилийн төсөв	
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах зардлыг 2020 оын төсөвт суулгасан. 50%		
		Албан хаагчдын хамрагдалт	100%			
Хэсгийн дундаж: 89.5 %						
<b>Үнэлгээний дундаж хувь: 90.0%</b>						

Албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор 2019 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд 2019 онд давхардсан тоогоор 4 албан хаагч гадаад улсад, 20 албан хаагч дотоодын сургалт, семинарт оролцож, туршлага судалж, мэдлэгээ дээшлүүлсэн. Үүнд:

**Гадаад сургалтаар:**

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дюссельдорф хотод зохион байгуулагдсан “Дулаан, эрчим хүчний хуримтлуур-2019” олон улсын үзэсгэлэн, семинарт 1 албан хаагч;
- Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод зохион байгуулагдсан “Байкал трейд 2019” бизнес форумд 1 албан хаагч;
- Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Штутгарт хотод туршлага судлах хөтөлбөрт 1 албан хаагч;
- Тайланд Улсад “Азийн хотуудын агаарын чанарын бүс нутгийн зөвлөлдөх уулзалт”-д 1 албан хаагч
- Хятад улсын Бээжин хотод 2019 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Бээжин хотын агаарын бохирдлыг бууруулах нь” сэдэвтэй зохион байгуулагдсан олон улсын хуралд 1 албан хаагч
- Бүгд найрамдах Солонгос улсад Пан-Азийн хотуудын хүрээлэн буй орчны асуудал сэдэвт уулзалтад 1 албан хаагч тус тус оролцсон.

**Дотоод сургалтаар:**

- Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилд 2 албан хаагч,
- ХБНГУ-ын Байгаль орчны агентлаг болон Цаг уур, орчны шинжилгээний газраас хамтран зохион байгуулсан “УБ хотын цаг уурын болон өгөгдөл солилцох тархалтын загварчлалыг сонгох” сэдэвт сургалтанд 2 албан хаагч;
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөл” сэдэвт багц сургалтад 7 албан хаагч;
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Төрийн захиргааны төв байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалт"-д 1 албан хаагч;

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гарсан журмуудыг танилцуулах сургалтад 3 албан хаагч;
- Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Нийслэлийн Төрийн захиргааны байгууллагуудын удирдлагын дарга, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн нарт зохион байгуулсан арга зүйн сургалтад 1 албан хаагч;
- Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, тус хуулийн өөрчлөлтөөр дагалдан шинэчлэн батлагдсан журмуудыг танилцуулах сургалтад -3 албан хаагч;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ажлын хэсгээс зохион байгуулсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтад 1 албан хаагч,
- Азийн цэвэр агаар" олон улсын байгууллага, БОАЖЯ хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд "Ялгарлын инвенторийн гарын авлага"-ын сургалтад 3 албан хаагч,
- Нутгийн захиргааны байгууллагын "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах" арга зүйн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан.

Байгууллагын нийт 17 албан хаагчийн хувийн хэргийг шинэчилж, шинээр ажилд орсон 6 албан хаагчид хувийн хэрэг үүсгэж холбогдох баримтуудыг хавсарган хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан. Албан хаагчдын нэгдсэн судалгааг боловсрол, ажилласан жил, зэрэг зэв, томилгоо, сахилга шийтгэл, сургалтад хамрагдсан байдал, шагнал урамшуулал зэрэг үзүүлэлт тус бүрээр шинэчлэн гаргасан.

Байгууллагын албан хаагчдын "Ээлжийн амралт эдлүүлэх хуваар"-ийг Газрын даргын 2019 оны А/15 дугаар тушаалаар батлуулж хэрэгжилтийг хангуулан ажилласан. 2019 оны жилийн эцсийн байдлаар 12 албан хаагч ээлжийн амралтаа хугацаанд нь биеэр эдэлж, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй 2 албан хаагчид холбогдох хууль журмын дагуу 1,5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшууллыг олгосон.

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын хүрээнд байгууллагын албан хаагчдын 2019 оны ажлын гүйцэтгэлийг улирал бүр үнэлж дүгнэн, ажиллагсдыг шагнаж урамшуулсан. 2019 оны 4 дүгээр улирлын үнэлгээгээр "хангалттай" дүгнэгдсэн 15 албан хаагчдад Газрын даргын тушаалаар мөнгөн урамшуулалыг олгосон.

Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

-Удирдлагын академийн Төрийн алба, удирдлагын сургуульд "Төрийн захиргааны менежмент" чиглэлээр мэргэшил дээшлүүлэх дипломын "Гараг"-ийн ангид суралцагч 2



---

албан хаагчид суралцах нөхцлийг /Мягмар гарагт цалинтай чөлөө олгох/ байгууллагаас бүрэн ханган өгч ажилласан. Дээрх албан хаагчид Төрийн алба, удирдлагын сургуулийг 2019 оны 12 сард амжилттай дүүргэж төгссөн.

-“Цагаан сар” билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдрийг тохиолдуулан байгууллагын өндөр настан Ч.Сэдэдэд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын дагуу 200 000 төгрөгийн мөнгөн тэтгэмж;

-Гэр бүлийн гишүүн /эмэг эх/ нь нас нөгчсөн Агаарын чанарын хяналтын хэлтсийн 2 албан хаагчийн ар гэрт 200 000 төгрөгийн мөнгөн тэтгэмж;

-Хүүхэд асрах чөлөөтэй байгаа Захиргааны хэлтсийн 2 албан хаагчид байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 600 000 төгрөгийн тэтгэмж;

-6 сарын 1. Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, гэр бүлийг дэмжих үүднээс 660 000 төгрөгийн тэтгэмж,

- Шинээр ам бүл нэмсэн Агаарын чанар, хяналт зохион байгуулалтын хэлтсийн 1 албан хаагчид байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 200 000 төгрөгийн тэтгэмж олгох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн.

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-г шинэчлэн баталсан бөгөөд журамд албан хаагчдын албан томилолт, чөлөө олголт зэрэг хөдөлмөрийн харилцаа, цаг ашиглалтыг нарийвчлан зохицуулсан.

ЗГ-ын Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2018 оны 258 дугаар тогтоол, НЗД-ын "Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай" 2017 оны 02 дугаар албан даалгаварыг байгууллагын албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, Газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн А/12 дугаар тушаалаар байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулсан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, хүндэтгэх шалтгаангүйгээр ажил тасалсан 1 албан хаагчид албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 15 хувиар бууруулах сахилгын хэмжээ ногдуулсан.

Албан хаагчдын ажлын цагийг автомат цаг бүртгэлийн системээр бүртгэн хяналт тавьж, хоцорсон тасалсан цагийг цалингийн тооцоотой уялдуулан тооцож байна.

### **ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ:**

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд нийт 315 өргөдөл, гомдол ирсэнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 262, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 23, судалж байгаа 30 өргөдөл, гомдол байна.

Хүснэгт 16. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал / хэлтэс, нэгжээр/

Нэгж/хэлтэс	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Нийт
Удирдлага	-	-	-	-
Захиргаа удирдлагын хэлтэс	32	6	12	50

<b>Бодлогын хэрэгжилтийн хэлтэс</b>	131	13	15	159
<b>Агаарын чанарын хяналтын хэлтэс</b>	99	4	3	106
<b>Нийт</b>	262	23	30	<b>315</b>

2019 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 11 цаг, 25 минут байгаа нь 2018 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаатай харьцуулахад 2 хоног 10 цаг 18 минутаар багассан үзүүлэлттэй байна.

Байгууллагад цаасаар ирсэн өргөдөл гомдлыг скайнердаж [www.smartcity.mn](http://www.smartcity.mn)-д оруулан байгууллагын удирдлагад шилжүүлэн ажиллаж байна.

Албаны албан хаагчдаас ирсэн өргөдөл гомдлыг бүртгэн удирдлагад тухай бүрт нь танилцуулан хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэнд шилжүүлэн ажиллаж байна.

### **АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТАЛААР:**

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны Ерөнхий хууль, Монгол хэлний тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Стандартчилал Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим баримт бичгийн солилцоо” стандарт /MNS ISO 17933:2008/, 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт” /MNS 5140-1:2011, MNS 5140-2:2011, MNS 5140-3:2011/, нийслэлийн Засаг даргын 2017 оны 252 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”-ыг дагаж мөрдөж байна. НЗД-ын 2017 оны 252 дугаар захирамжаар батлагдсан журмыг үндэслэн Байгууллагын дотоодод “Албан хэрэг хөтлөлтийн журам”, “Архиваас баримт ашиглуулах журам”-ыг тус тус боловсруулж Газрын даргаар батлуулан мөрдөж байна.

МУ-ын ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 46 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах тухай” А/518 дугаар захирамжийн дагуу байгууллагын хэмжээнд Архивын үзлэгт бэлтгэх комисс байгуулж, ажлын төлөвлөгөө гарган Газрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажилласан. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт батлагдсан удирдамж, дүгнэх үзүүлэлтийн дагуу бэлтгэж, үзлэгт хамрагдсан.

**Албан бичиг хөтлөлт:** Газрын хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 1522 албан бичиг ирсэнээс хариутай бичиг 1082, хариугүй 440 албан бичиг бүртгэгдсэнийг тухай бүр шийдвэрлэж ажилласан байна. Нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл хугацаандаа шийдвэрлэсэн - 1431, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн -53, шийдвэрлэх шатандаа байгаа - 38 албан бичиг байна. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 97.96 хувьтай байна. Хүснэгт -17.

Хүснэгт -17. Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт 2019 онд ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

№	Нэгж	Нийт	Хариугүй	Хариутай	Хугацаандаа шийдвэрлэсэн	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	Тооцогдсон зөрчлийн тоо	Шийдвэрлэлтийн%
1	Удирдлага	16	13	3	16	-	-	100%
2	Захиргааны хэлтэс	492	158	334	461	18	13	97.67%
3	Бодлогын хэрэгжилтийн хэлтэс	621	199	422	574	26	21	97.48%
4	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтэс	393	70	323	380	9	4	98.87%
	Нийт	1522	440	1082	1431	53	38	97.96%

Тус газраас холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд 898 албан бичиг явуулсан ба албан бичгийн бүрдүүлэлт, стандартыг мөрдөж, хяналт тавин ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн Edoc.ub.gov.mn, программын шинэчлэлт болон хэрэглэх заавар зөвлөмжийг нийт албан хаагчдад танилцуулан үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж хэвшсэн.

**Архив бүрдүүлэлт, хадгалалт ашиглалт:**

2019 онд архивын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллалаа. Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар батлагдсан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг үндэслэн 2019 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2019 оны ХХНЖ-ыг байгууллагын дэргэдэх БНШК-ын 1 –р хурлаар хэлэлцүүлж Газрын даргаар батлуулан баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.


Байгууллагын 2018 оны ХХНЖ-ын дагуу санхүүгийн ажилтнаас 77, БХХ-ээс 24, АЧХЗБХ-ээс 34, ЗХ-ээс 56 нийт 191 хадгаламжийн нэгж, 6 цахим баримт хүлээн авсан.

Тус байгууллагын архивт нийт 953 цаасан суурьт баримт хадгалагдаж байгаагаас

- Байнга хадгалах 255
- Түр хадгалах 667
- 70 жил хадгалах 31
- Тусгай төрлийн баримт буюу дүрс бичлэгийн 48, гэрэл зургийн 1 баримт хадгалагдаж байна.

БНШК-ыг Газрын даргын 2019 оны А/54 тушаалаар шинэчлэн байгуулж 2019 онд 2 удаа хуралдаж ХХНЖ-ийг шинэчлэх, архивын баримтыг сэлбэн засах, хуудас дугаарлах,

баримтын нүүр бичвэр бичих зэрэг баримтын техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. “Архивын баримтад улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын дагуу байгууллагын архивын баримтын тоон мэдээг хугацаанд нь гаргаж НАГ-т албан тоотоор хүргүүлж ажилласан.



*Зураг 41. Архивын баримтад техник боловсруулалт хийх үйл ажиллагаа*

2019 онд архив, бичиг хэргийн ажилтан өөр албан тушаалд шилжин ажиллах болсонтой холбогдон архивын баримтын тооллогыг хийж баримтыг акт үйлдэн хүлээлцэх ажлыг зохион байгуулсан.

Газрын даргын А/48 дугаар тушаалаар 5.02 сая төгрөгийг төсөвлөн архивын өрөө /7.54 м<sup>2</sup>/ гарган архивын зориулалтын тавиур, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч архивын өрөөг тохижуулан Архивын баримтыг он цаг, нэр төрлөөр ангилан төрөлжүүлж хадгаламжийн санд баримтын заагуур, заагчийг байрлуулсан. “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм”, “Архивын баримтын эрсдэлээс хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд архивын өрөөнд галын самбар, галын буланг байгуулсан. Гамшгийн эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан ажиллаж байна.



*Зураг 42. Архивын баримтын хадгалалтын байдал*

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчдад архивын баримтыг ашиглуулах, мэдээ, лавлагаа гарган үйлчилж байна. 2019 онд 3 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр архивын лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

**ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:**

ЗГ-ын Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 2018 оны 258 дугаар тогтоол, НЗД-ын "Сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай" 2017 оны 02 дугаар албан даалгаварыг байгууллагын албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тус газартай бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй 4 аж ахуйн нэгж, байгууллагыг шүүх, хуулийн байгууллагад өгч нэхэмжлэл гарган шүүх хуралдаанд байгууллагыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажилласан. Шүүхээс Номгон хайрхан ХХК-д хамаарах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ба Тара ХХК, "Ворм энержи" ХХК-иудад хамаарах нэхэмжлэлийг нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлага, бараа, тоног төхөөрөмжийн эзэмшигч, ашиглагчыг тодорхой болгох үүднээс шүүхээс нэхэмжлэлийг эргүүлэн татсан. /Хүснэгт-18-д харуулав./

Хүснэгт 18. Шүүх, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан талаарх мэдээлэл

д/д	Нэхэмжлэгч	Хариуцагч	Нэхэмжлэлийн агуулга	Шүүхийн шийдвэр	Тайлбар
1	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	"Тара" ХХК	Түлш нийлүүлэх гэрээний үүрэг зөрчсөн тул алдангийн хамт 214,555,625 төгрөг гаргуулахаар нэхэмжилсэн.	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 181/ШШ2017/03227 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 621 дүгээр магадлалтай, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 001/хт2018/01086 дугаар тогтоолоор шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Тус иргэний хэрэг шүүхэд хянагдах явцад тоног төхөөрөмжийн өмчлөлийг тодорхой болгох шаардлагын үүднээс нэхэмжлэлийг буцаан татсан.	



2	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	“Ворм энерги” ХХК	Түлш нийлүүлэх гэрээний үүрэг зөрчсөн тул алдангийн хамт 171,230.561 төгрөг нэхэмжилсэн.	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 101/ШШ2018/01114 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2008 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1311 дүгээр магадлалтай, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 001/хт2018/01648 дугаар тогтоолоор шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Тус иргэний хэрэг шүүхэд хянагдах явцад тоног төхөөрөмжийн өмчлөлийг тодорхой болгох шаардлагын үүднээс нэхэмжлэлийг буцаан татсан.	
3	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	Номгон хайрхан ХХК	Халаалт болон ахуйн хэрэглээний хосолмол цахилгаан зуух нийлүүлж, суурилуулах гэрээний үүрэг зөрчсөн тул 23,925.000 төгрөг нэхэмжилсэн.	Баянхонгор аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 131/ШШ2018/00897 шийдвэрээр Хариуцагч Т.Чинбат нь шүүхэд хэрэг хянагдах явцад буюу 2018 оны 08 сарын 11-ний өдөр нас барсан болох нь 000186979 дугаартай нас барсны гэрчилгээгээр тогтоогдсон. Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1-д гэрээний үүрэгтэй шалгах хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байхаар хуульчилсан. Гэтэл	Хурал зарлагдаагүй байна.

				нэхэмжлэгч нь шаардах эрх үүссэнээс хойш 6 жил 5 сарын дараа буюу хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсний дараа шүүхэд хандсан байх тул шүүх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэх боломжгүй, гэрээний үүрэг 23 925 000 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.	
4	Нийслэлийн Агаарын бохирдолтой тэцэх газар	“Их эрин элч” ХХК	Гэрээний үүргээ биелүүлээгүй тул эрүүгийн хэрэг үүсгэх хүсэлтийг ЧД-ийн цагдаагийн хэлтэст гаргасан.	Шалны цахилгаан халаагуурыг гэр хорооллын айл өрхөд нийлүүлэх №ЦА6789 дугаартай тендерт шалгарсан “Их эрин элч” ХХК-тай “Бүтээгдэхүүн нийлүүлэх, суурилуулах гэрээ”-г 2010 оны 08 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан. “Их эрин элч” ХХК-ийн ерөнхий захирал Д.Түмэнхүүд гэрээний үүргээ гүйцэтгэхийг шаардаж байсан боловч ажлын байран дээр байдаггүй, зарлан дуудах хуудас авдаггүй, хаяг тодорхойгүй тул Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргасан.	

#### **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

“Бараа, ажил, үйлчилгээ 2019 онд худалдан авах ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан газрын даргаар батлуулан [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) -д байршуулж олон нийтэд ил тод зарлан мэдээлсэн.

Тус байгууллагын урсгал зардалд төсөвлөгдсөн нийт 87,4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 3 арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг НХААГ-аар дамжуулан, 50,0 сая төгрөгийг батлагдсан төсөвт өртөгтэй 1 ажлыг байгууллага дээрээ зохион байгуулж худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д тендерийн урилга, зар, тендерийн холбогдолтой баримт бичиг болон сонгон шалгаруулалтын үр дүнг мэдээлж ажилласан.

---

### **ТӨСӨВ САНХҮҮ, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн ханын самбарт байршуулж төсвийн ил тод байдлыг ханган ажиллалаа.

2019 оны 12 дугаар сарын 25-ны байдлаар 535,054,800.0 (таван зуун гучин таван сая тавин дөрвөн мянга найман зуун )төгрөгийн урсгал санхүүжилт авч, Агаар орчин болон агаар бохирдуулагч эх үүсвэрт хийсэн хэмжилтийн орлого 23,646,000.0 (хорин гурван сая зургаан зуун дөчин зургаан мянган) төгрөгийн орлого оруулсан байна. Төсвийн орлогыг 13,646,000 төгрөгөөр давуулж биелүүлсэн. Төсвийн урсгал зардалд 462,344,362.0 ( дөрвөн зуун жаран хоёр сая гурван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун жаран хоёр)төгрөгийг зарцуулсан.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 135,500,0 /нэг зуун гучин таван сая таван зуун мянган/ төгрөг төвлөрүүлсэн. Төсвийн зарлагын данс хаах өдрөөр /2019.12.25/ нийт нэмэлт дансны 11,854,300,0 /арван нэгэн тэрбум найман зуун тавин дөрвөн сая гурван зуун мянган/ төгрөгийн төсвийн дансны 4,516,633.7 /дөрвөн тэрбум таван зуун арван зургаан сая зургаан зуун гучин гурван мянган долоон зуун/ төгрөгийн гүйлгээг хугацаанд нь шилжүүлсэн. Мөн 292,582,900 /хоёр зуун ерөн хоёр сая таван зуун наян хоёр мянга есөн мянган/ төгрөгийн барьцааг чөлөөлсөн.

### ***“Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ:***

Тус газрын үйл ажиллагааны чиг үүрэгтэй хамаарал бүхий НЗД-ын 13 захирамж, НЗД-ын зөвлөлийн хурлын 8 тэмдэглэл, нийслэлийн Онцгой комиссын хурлын 5 тэмдэглэл, НЗД-ын 1 албан даалгавар, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1 тогтоолын нийт 41 заалтыг хяналтанд авч хэрэгжилтийг **Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан** [monitoring.ub.gov.mn](http://monitoring.ub.gov.mn) –д болон албан бичиг, цахим хаягаар тайлагнаж ажиллав.

1. НЗД-ын 13 захирамжийн 19 заалтын хэрэгжилт 92.57%
2. НЗД-ын 1 албан даалгаврын 2 заалтын хэрэгжилт 82.8 %
3. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1 тогтоолын 3 заалтын хэрэгжилт 75.0% -тай хэрэгжсэн байна.

---

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

*Үйл ажиллагааны ил тод байдал:*

Байгууллагын [www.aprd.ub.gov.mn](http://www.aprd.ub.gov.mn) цахим хуудсанд байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалтын схем, тус байгууллагаас үзүүлдэг үйлчилгээний тухай мэдээлэл, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, газрын даргын тушаалыг тухай бүр байршуулж ажиллаж байна.

Тус байгууллага нь 2019 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцийн чиглэлээр 53, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 98, нийт 151 захирамжлалын баримт бичиг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна.

Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг тухайд нь хагас, бүтэн жилээр, улирал, сар, тухай бүр гэсэн хугацаагаар ангилж, хавсралтын дагуу мэдээллэн ажиллаж байна. Мөн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт цаг тухай бүр байршуулж, төсвийн ил тод байдлыг ханган ажилласан. Байгууллагын шилэн дансанд нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, байгууллагын батлагдсан орон тоонд гарсан өөрчлөлтүүд, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүссэн шийдвэр болон бусад холбогдох мэдээ тайланг байршуулж мэдээллэн ажиллаж байна.

Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмын төсөлд олон нийтийн санал авахаар 2019 оны 04-р сарын 24-нд байгууллагын цахим хуудсанд байрлуулан санал авсан. <http://aprd.ub.gov.mn/n/6419>

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 2017.06.07-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмын хүрээнд UBlegal.mn цахим хуудсанд 2019 оны “А” тушаал 98, “Б” тушаал 53-г тус тус бүртгэсэн.

Нийслэлийн агаарын чанарын суурин харуулын мэдээг цаг тухайд нь онлайнаар [www.agaar.mn](http://www.agaar.mn), [www.aprd.ub.gov.mn](http://www.aprd.ub.gov.mn), [www.aqicn.org](http://www.aqicn.org) сайтуудаар, суурин харуулын байршил бүрд болон БОАЖЯ, нийслэлийн нутгийн захиргааны байр Хангарди ордон, УЦУОШГ-т байрлах дэлгэцүүдээр, мөн гар утасны “Агаар” аппликейшнээр иргэд, олон нийтэд мэдээллийг хүргэн ажиллаж байна.

*Хүний нөөцийн ил тод байдал:* Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ажлын байранд мөрдөх дэглэм, Хүний нөөцийн хөгжил хөтөлбөр зэргийг <http://new.aprd.ub.gov.mn> цахим хуудсанд байршуулж мэдээллийн самбараар мэдээллэж ажиллалаа. Хувийн ашиг сонирхолын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 7 албан тушаалтны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) мэдүүлгийн цахим

системд оруулж баталгаажуулалтыг хийж ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайланг хуулийн дагуу тайлагнасан.

www.shilendans.gov.mn-д сар бүр оруулах мэдээлэлд албаны бүтэц орон тоотой холбоотой мэдээллийг, тухай бүр оруулах мэдээлэлд худалдан авах, хөрөнгө мөнгө зарцуулах ажиллагаатай холбоотой мэдээллийг тус тус тогтмол оруулж, баталгаажуулж байна.

## ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 19. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт

№	Шалгуур үзүүлэлт		Хувь
<b>Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал</b>			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын үйл ажиллагааны стратегийн үндсэн зорилго, зорилтуудыг цахим ( <a href="http://aprd.ub.gov.mn/c/22">http://aprd.ub.gov.mn/c/22</a> ) хуудас болон мэдээлийн самбарт байрлуулж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Иргэдийг хүлээн авах цагийн хуваарийг батлуулан мэдээллийн самбартаа байрлуулан, өргөдөл гомдлыг ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд байнга хүлээн авч ажиллаж байна.	100
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үндсэн 3 үйлчилгээ үзүүлж байна. Үүнд: 1.Зуух болон түлшний хаягдал утааны хийн хэмжилт хийх 2. Орчны агаарт хэмжилт хийх 3. Авто тээврийн хэрэгслийн хаягдал утааны хийн хэмжилт хийх Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтыг байгууллагын цахим хуудас ( <a href="http://new.aprd.ub.gov.mn/c/8/3">http://new.aprd.ub.gov.mn/c/8/3</a> ) ба мэдээлийн самбарт байршуулан ажиллаж байна.	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үйл ажиллагаанд мөрдөж байгаа эрх зүйн баримтыг дараах байдлаар <a href="http://.aprd.ub.gov.mn/k?mID=27">http://.aprd.ub.gov.mn/k?mID=27</a> , <a href="http://aprd.ub.gov.mn/c/8/3">http://aprd.ub.gov.mn/c/8/3</a> цахим болон байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байрлуулан ажиллаж байна.	100



5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөх журмын төсөлд олон нийтийн санал авахаар 2019 оны 04-р сарын 24-нд байгууллагын цахим хуудсанд байрлуулан санал авсан. <a href="http://aprd.ub.gov.mn/n/6419">http://aprd.ub.gov.mn/n/6419</a>	100
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх нэгдсэн стандартад нийцүүлэх, операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг болгон өөрчлөх арга хэмжээтэй холбогуудлан тус байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг үйлчилгээний нэр төрөл, түүний эрх зүйн зохицуулалт, баримт бичгийн бүрдэл, төлбөр хураамжийн талаарх мэдээлэл болон операторын үйлчилгээг үзүүлэх албан хаагчдад мэргэжлийн ур чадвар олгох сургалтын модулийг боловсруулан НҮНТ-д хүргүүлсэн.	100
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	-	
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	-	

9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хийсэн санамж бичгийн дагуу Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх төслийн 3 дугаар үе шат 2018 оны 12 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлсэн. Төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудсанд тухай бүр байрлуулан олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.	100
<b>Хэсгийн дундаж хувь: 100%</b>			
<b>Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;</b>			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна	100
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ажлын байранд мөрдөх дэглэмийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. ( <a href="http://new.aprd.ub.gov.mn/k/11?mID=33">http://new.aprd.ub.gov.mn/k/11?mID=33</a> )	100
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийг цахим хуудсанд байршуулсан. ( <a href="http://new.aprd.ub.gov.mn/c/11/13">http://new.aprd.ub.gov.mn/c/11/13</a> )	100
4	Хүний нөөцийн удирдлалгын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын танилцуулга, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, Даргын тушаал, ажлын байрны тодорхойлолт зэргийг цахим хуудсанд байршуулж мэдээлсэн.	100
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг цахим хуудсанд байршуулсан. ( <a href="http://new.aprd.ub.gov.mn/c/11/13">http://new.aprd.ub.gov.mn/c/11/13</a> )	100
<b>Хэсгийн дундаж хувь: 100</b>			
<b>Хэрэгжилтийн дундаж хувь: 100</b>			

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

### **Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай**

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас техникийн туслалцаагаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” (3-р үе шат)-ийн Хамтарсан зохицуулах хорооны 2 дугаар хуралдааныг 2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр, 3 дугаар хуралдааныг 12 дугаар сарын 05-ны өдөр Төслийн багтай хамтран Хангарди ордны хурлын танхимд тус тус зохион байгуулсан. Төслийн багийн нийслэлийн бусад байгууллага, албан тушаалтнуудтай уулзах уулзалтын цаг товлох, шаардлагатай мэдээ мэдээлэл өгөх зэрэг төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Азийн агаарын чанарыг сайжруулах нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд (IBAQ programme) "Азийн цэвэр агаар" олон улсын байгууллага, БОАЖЯ хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд "Ялгарлын инвенторийн гарын авлага"-ыг Япон Улсын Агаарын бохирдлын судалгааны Азийн төв байгууллагаас боловсруулсан. Тус гарын авлагыг эцэслэн Монголын талын холбогдох мэргэжлийн байгууллага, шинжлэх ухаан, судалгааны байгууллагуудын хүрээнд хэлэлцүүлэн таниулах, хүлээлгэн өгөх хаалтын семинар 2019 оны 3-р сарын 12-ны өдөр зохион байгуулагдаж "Ялгарлын инвенторийн гарын авлага"-ыг хүлээлгэн өгсөн.



*Зураг 43. Азийн цэвэр агаар" олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Ялгарлын инвенторийн гарын авлага" хүлээлгэн өгөх үеийн зураг*

“ТҮЛШЭЭ НӨӨЦӨЛЬЕ” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдэд зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. Тус тогтоолоор сайжруулсан түлшний эрэлт нийлүүлэлт, түгээлт борлуулалт, нөөцлөлтийн тэнцвэрт байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргад үүрэг болгосон. Мөн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд “Төрийн албан хаагчдад сайжруулсан түлшийг дараа төлбөр хийх нөхцлөөр олгох асуудлыг судлан танилцуулах” үүрэг өгөгдсөн. Энэхүү тогтоол, хурлын тэмдэглэлээр

өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд “Түлшээ нөөцөлье” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, “Таван Толгой Түлш” ХХК хамтран зохион байгууллаа. Тус уулзалтад НАБТГ, “ТТТ” ХХК, дүүргүүдийн засаг захиргааны нэгж болон орон нутгийн өмчит байгууллага, хороо цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаалтнууд оролцсон.



*Зураг 44. Дүүргүүдтэй хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэг*



*Зураг 45. Дүүргүүдэд зохион байгуулсан иргэдтэй хийсэн зөвлөлдөх уулзалт.*

Засгийн газрын 62-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянгол дүүргийн 10, 23, 12 дүгээр хорооны хяналт судалгааны ажилтнуудад амьдрах орчны судалгаа болон тогтоолыг сурталчлах ажлыг 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулан мэдээлэл өгч ажиллалаа.





Зураг 46. “Амьдрах орчны судалгаа”-ны сургалт зохион байгуулагдаж байгаа нь

“Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хүрээнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, сайжруулсан шахмал түлшний түгээлт борлуулалтын тогтолцооны талаар дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар болон хороодтой гэрээ байгуулан ажиллаж буй хяналтын багийн гэрээт ажилтнуудад мэдээлэл өгөх, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Цэвэр агаартай хотын төлөө” зөвлөгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Улаанбаатар палас”-д зохион байгуулсан. Зөвлөгөөнд агаар орчны бохирдлын талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого, сайжруулсан түлшний борлуулалт, түгээлтийн байдал, түүнд тавих хяналтын талаар НЗД-ын орлогч Д.Мөнхжаргал, НМХГ, ЗАА-ын Инженерийн байгууламжийн хэлтэс, НЭМГ, НСГ, “Таван толгой түлш” ХХК зэрэг хоблогдох байгууллагуудаас нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын 95 хорооны IV түвшний 3900 гаруй орон тооны бус гэрээт ажилтнуудад мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Мөн зөвлөгөөний үеэр агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарагдах 95 хороодод идэвх санаачлагатай ажиллаж ажлын үр дүнгээрээ шалгарсан 380 орон тооны бус гэрээт ажилтнууд, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашиглан халаалтаа шийдсэн, гэр сууцаа дулаалсан шилдэг 1 өрхийг хороо тус бүрээс шалгаруулан шагнаж урамшуулсан.



Зураг 47. “Цэвэр агаартай хотын төлөө” зөвлөгөөн. 2019.12.16.





*Зураг 48. Орон тооны бус гэрээт ажилтнууд болон шилдэг өрхөөр шалгарсан айл өрхийг шагнаж урамшуулав.*

Зөвлөгөөний үеэр орон тооны бус ажилтнуудад “Угаарын хордлогын үед үзүүлэх анхан шатны тусламж үзүүлэх” гарын авлагыг 3000 ширхэгийг тараасан.

МУИС, АШИҮИС, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хамтран дотоод орчны агаарыг сайжруулах, иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор “Ханан дундах хүүхэд нас” Монголын дотоод орчны агаарын чанарын анхдугаар симпозиумыг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан.

Засгийн газрын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 20, Сонгинохайрхан дүүргийн 21, Хан-Уул дүүргийн 12, 13, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт түүхий нүүрсийг хэрэглэхийг хориглоогүй бөгөөд энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч, аж ахуй нэгж байгууллага, иргэдтэй 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдөр мэдээлэл солилцох уулзалтыг зохион байгуулсан. Тус хорооны иргэдээс түүхий нүүрсний үнэ, тээвэрлэлт, борлуулалтын өртгийг хэрхэн зохицуулах талаар ярилцаж, хороод иргэдийг мэдээлэл, арга зүйгээр хангаж ажиллаж байна.



*Зураг 49. ХУД-ийн 12-р хорооны иргэдтэй хийсэн уулзалт*

**Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаар:**

Хүснэгт 20.

№	Иргэд, аж ахуйн нэгж байгууллага	Хүсэлт, өргөдлийн товч утга	Шийдвэрлэсэн байдал
<b>А</b>	<b>Орчны хэмжилт болон халаалтын зуух, түлшний хэмжилтийн талаар</b>		
1	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар	Хамтран ажиллах тухай	Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны агаарын чанарт 2019 оны 05 дугаар сарын 7- 8-ний өдрүүдэд 24 цагийн турш хэмжилт хийж 2019 оны 05 дугаар сарын 17 өдрийн 03/257 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.
2	ШУТИС Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	Шинжилгээ хийлгэх тухай	ДТХ-0,35мВт хүчин чадалтай зуухны хэмжилтийг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хийж, хэмжилтийн дүнг боловсруулан 05 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлээ.
3	Азийн хүүхдүүд цэцэрлэг,	Шинжилгээ хийлгэх тухай	Халаалтын зууханд хаягдал утааны хэмжилт хийж 2019 оны 04 дугаар сарын 05- ны өдөр хариуг хүргүүлсэн.
4	Эко авто моторс ХХК, Д.Эрдэнэболд	Шинжилгээ хэмжилт хийлгэх тухай	Орчны хэмжилтийг 2019 оны 05 дугар сарын 13-ны өдөр хийж, хэмжилтийн дүнг боловсруулан 20 -ны өдөр хариу хүргүүлээ.
5	Монгол сайжруулсан түлш ХХК, Ч.Нэргүй	Хүсэлт гаргах тухай.	Сайжруулсан түлшний хэмжилтийг 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдөр хийж, хэмжилтийн дүнг боловсруулан 05 дугаар сарын 01-ны өдөр хүргүүлээ.
6	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүсэлт гаргах тухай	Халаалтын зууханд хаягдал утааны хэмжилт хийж хариуг 2019 оны 05 дугаар сарын 27- ны өдөр хүргүүлсэн.
7	Их Соёмбо” авто угуулга	Хэмжилт хийлгүүлэх тухай	Орчны хэмжилтийг 2019 оны 05 дугар сарын 02-ны өдөр хийж, хэмжилтийн дүнг боловсруулан 20 -ны өдөр хариу хүргүүлээ.
8	“ОКФИЛ ЭКО” ХХК,	Хэмжилт хийлгүүлэх тухай	Агаар цэвэршүүлэх төхөөрөмжийн үр дүн тодорхойлох хэмжилтийг 2019 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хийж, хэмжилтийн дүнг боловсруулан 03 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлээ.
9	"БЛЕЙЗ ТЕК" ХХК,	Хэмжилт хийлгэх тухай	"БЛЕЙЗ ТЕК" ХХК-ны хүсэлтийн дагуу 2019 оны 11 дүгээр сарын 8,9-нд Плэйм гэрийн зууханд хаягдал утааны хэмжилт хийж дүнг боловсруулав.
10	Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтэс,	Хэмжилтийн дүн ирүүлэх тухай	БЗД-ийн 17 дугаар хорооны ...-ий... тоотод хийсэн хэмжилтийн дүнг боловсруулан даргын албан үүрэг гүйцэтгэгчийн 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 03/599 дугаартай албан бичгээр хариу хүргүүлээ. 2019.10.18 өдрийн 3/599 (Я2000629094) тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.
<b>Б</b>	<b>Автотээврийн хэрэгслээс ялгарах бохирдлыг бууруулах талаар</b>		
1	Эс Ай Си Эй ХХК, Г.Эрдэнэ	Санал авах тухай	"Ашиглалтаас гарсан аккумуляторын батареиг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах стандарт"-ын төсөлтэй танилцаж холбогдох саналыг боловсруулан 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 03/114 дугаартай албан бичгээр хүргүүлээ.
2	Зам, тээврийн хөгжлийн яам, Г.Гантулга	Стандартын нэмэлт, өөрчлөлтийн	Зам,тээврийн хөгжлийн яамны “стандартын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал ирүүлэх тухай” 2019 оны 04 дүгээр сарын 16- ны өдрийн 07/1827 дугаартай албан

		төсөлд санал ирүүлэх тухай.	бичигтэй танилцаж холбогдох саналыг боловсруулан 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 03/214 дугаартай албан бичгээр хариуг хүргүүллээ.
3	Зам, тээврийн хөгжлийн яам, С.Батболд	Санал ирүүлэх тухай	Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 05 дугаар сарын 03 -ны өдрийн 03/2258 дугаартай албан бичгээр ирүүлсэн стандартын төсөлтэй танилцлаа. Тус стандартын төсөлд Газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 3/274 дугаартай албан бичгээр санал хүргүүллээ.
4	АЙ ЭС ӨҮ ӨҮ ХХК, Ч.Өгөөдэйбаатар	Хүсэлт гаргах тухай.	Тус комданийн 2019 оны 05 дугаар сарын 06/01 дугаартай албан бичигтэй танилцлаа. Газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 07ны өдрийн 03/294 дугаартай албан бичгээр хариу хүргүүллээ.
5	Глобал моторс ХХК, С.Баатар	Хүсэлт гаргах тухай	Ту компанийн ажилтан Сүхболдтай 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 99075642 утсаар холбогдож Хангарди ордны 501 тоотод уулзалт зохион байгуулж, үйл ажиллагаатай нь танилцсан. Мөн Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 03/690 дугаартай албан тоотоор хариу хүргүүллээ. 2019.11.04 өдрийн 3/690 дугаартай албан бичгээр хариуг хүргүүлэв.
6	Сабертек LLC, Сергио Варкала Сангиовани	Хэмжилтийн дүнгийн тухай	Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2019 оны 11 дүгээр сарын 04ний өдрийн 03/692 дугаартай албан тоотоор хариу хүргүүллээ. 2019.11.04 өдрийн 3/692 (Я2000641416) тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.
3	<b>Суурин харуул болон мэдээлэл технологийн талаар</b>		
1	Эм Ай Эс Эс ХХК, Д.Одхүү	Мэдээлэл дамжуулах төхөөрөмж холбох явцын тухай	2019 оны 01-р сарын 24-ны өдөр төхөөрөмжүүдийн холболтын талаар Эм Ай Эс Эс ХХК-тай мэдээлэл өгч хамтран ажиллав.
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Н.Батбаяр	Мэдээлэл ирүүлэх тухай	Албан тоотын хариуг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр 03/119 тоот албан бичгээр хариу өгч ажиллав.
3	Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар	Агаарын чанарын мэдээ авах тухай.	2019 оны 4-р сарын 16-ны өдөр tchuluun@worldbank.org цахим хаягаар агаарын чанарын 2017-2019 онуудын мэдээг өгсөн.
4	Монгол улсын их сургууль, Ү.Отгонбаяр	Мэдээлэл гаргуулах тухай	2019 оны 4-р сарын 17-ны өдөр 03/146 тоот албан бичгээр хариу хүргүүлэн ажиллав
5	Хэвлэлийн хүрээлэн ТББ, М.Мөнхмандах	Хүсэлт хүргүүлэх тухай	2019 оны 5-р сарын 1-ны өдрийн 03/207 дугаарт албан бичгээр хариу хүргүүлэв
6	Нью жуулчин турс ХХК, Ш.Нэргүй	Хүсэлт гаргах тухай.	Нью Жуулчин Турс ХХК-тай 2019 оны 4- р сарын 16-ны өдөр 319401 утсаар холбогдон мэргэжилтэн Саруултай холбогдон 4-р сарын 22-ны өдөр 16 цагт Баянхошууны суурин харуулд зураг авалт хийхээр төлөвлөв.
7	“Регал-инженеринг” ХХК	Хүсэлт гаргах тухай	2019 оны 7-р сарын 8-ны өдөр ажлын хэсэг байгуулан сэлбэгийг хүлээн авч санхүүжилтийн бичиг баримтыг бүрдүүлэн ажиллаж байна. 91119036 дугаарт холбогдон шийдвэрлэлтийн талаар хариу өгөв.

4	<b>Агаарын бохирдлыг бууруулах талаар</b>		
<b>1</b>	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Т.Булган	Мэдээлэл ирүүлэх тухай	Байгууллагын 2019 оны 01 дүгээр сарын 16ны өдрийн 03/24 дугаарт албан бичгээр холбогдох мэдээллийг хүргүүллээ.
<b>2</b>	УИХ-ын гишүүн Н.Учрал., Н.Учрал	Хүсэлт уламжлах тухай	Иргэн Ш.Алтангэрэлийн бүтээсэн дулааны эх үүсвэрийг дэмжиж ажиллахыг хүссэн 03/248 дугаарт албан бичгийг Нийслэлийн Шинжлэх ухаан, инновацийн газарт 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдөр уламжиллаа.
<b>3</b>	“ЭМ АЙ ЭС” ХХК, Накамура	Хүсэлт гаргах тухай	Хүлээн авах ажлын хэсэг 2019 оны 03- р сарын 20-ны өдөр Улаанбаатар Төмөр Замын Депод очиж шүүлтүүр суурилуулсан вагонуудтай танилцлаа.

---

### ***Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:***

Дотоод үйл ажиллагааны хүрээнд дотоод хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх, удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн 75 заалтад хяналт үнэлгээ, шинжилгээ хийн, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж биелэлтийн мэдээг тайлан, хурлын тэмдэглэлийн хамт НЗДТГ-т хүргүүлсэн.

Засгийн газрын 89-р тогтоол, НЗД-ын А/335 дугаар захирамж болон бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, тайлагнах хугацааг байгууллагын албан хаагчдад танилцуулсан.

Газрын 2019 оны дотоод хяналт шинжилгээ- үнэлгээний төлөвлөгөө, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Газрын даргаар батлуулан хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллалаа.

### ***Байгууллагын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын чиглэлээр:***

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан ажилласан. 2019 онд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 7 удаа хийж эд хогшил актлах, данснаас хасах, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой асуудлаар холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан байна. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 4 дүгээр сарын 08-ны хурлаар байгууллагын ашиглалтын шаардлага хангахгүй нийт 42 нэр төрлийн эд хөрөнгийг актлахаар шийдвэрлэж Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газарт хүсэлтээ албан бичгээр хүргүүлсний дагуу Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 5 дугаар сарын 13-ны А/115 тоот тушаалаар 5 нэр төрлийн 1795882 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн устгаж, 11 нэр төрлийн 6695919 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч данс бүртгэлээс хасаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөнийг хийсэн. 2018 оны Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэн бүрэн хангалттай үнэлгээ авсан.

Газрын даргын тушаалаар Эд хөрөнгийн тооллого хийх комиссыг байгуулж 2019 онд эд хөрөнгийн тооллогыг 2 удаа зохион байгуулан ажилласан. Ашиглалтын хугацаа дууссан, элэгдэлд орсон, эвдэрч ашиглах боломжгүй болсон 21 нэр төрлийн 34 ширхэг 4,254,930.0 төгрөгийн тавилга, эд хогшил, 26 нэр төрлийн 30 ширхэг 367,202,584.0 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 1 нэр төрлийн 1 программ хангамж, 6 нэр төрлийн 32 ширхэг 3,965,000.0 төгрөгийн авто тээврийн хэрэгсэлийн хөрөнгүүдийг нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/115 дугаар тушаалаар актлуулсан.

Байгууллагын албан ажлын хэрэгцээнд 2019 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 8,376,450.0 төгрөгийн бичиг хэргийн материал, 108,130,350.0 төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 8,650,000.0 төгрөгийн шатахуун талон, 206,394,882 төгрөгийн тусгай зориулалттай материал, 7,315,000 төгрөгийн бусад хангамжийн материал, 2,868,620 төгрөгийн багаж техник хэрэгслийг олгож, холбогдох тооцоог тухай бүр хийж ажилласан байна.



---

## ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

- Байгууллагын дотоод хяналт шалгалтыг сайжруулах.
- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй арга хэмжээнд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах.
- Агаар дахь бохирдуулагч бодисуудын агууламж, тэдгээрийн нөлөөллийг түвшинг индексээр илэрхийлж үнэн зөв бодитой, цаг хугацаанд нь гаргаж байхад анхаарах.
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа 12 хоног 10 цаг 18 минут байгааг багасгаж нийслэлээс тавьж байгаа нэг оронтой тоонд хүргэх гэсэн зорилтод хүрэх.
- Дотоод орчны агаарын чанарыг сайжруулах чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх.
- Суурин харуулуудын СО-угаарын хийн хэмжилтийн тоног төхөөрөмж, тэг хийн үүсгэгчийг шинэчлэх
- Суурин эх үүсвэрийн хэмжилтийн чадавхийг бэхжүүлэх, хэмжилтийн 2 баг бүрдүүлэх,
- Ажилтнуудын цаг ашиглалт, хөдөлмөрийн харилцаан дахь ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх.
- Хүний нөөцийн хуваарилалтыг оновчтой болгох, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх.

ХЯНАСАН: НАБТГ-ын ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ГАЛЫМБЕК

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.АМАРМАА